



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧИЙН БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН ДАГУУ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ

АУДИТЫН КОД: СНАГ-2025/09-НА-НА

АМГТГ НЬ ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН МЭДЭЭГ ХУГАЦААНД НЬ ХЯНААГҮЙГЭЭС ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛҮҮД ЗАЛРУУЛАГДААГҮЙ, ДАРААГИЙН ЖИЛҮҮДЭД ДАВТАН ГАРСНААР БАТАЛГААЖУУЛАХ АУДИТАД ХҮНДРЭЛ УЧИРЧ БАЙНА.

Улаанбаатар хот
2025 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/174

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх” нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлэхийг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Ц.Наранчимэг)-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын дарга, тэргүүлэх аудитор (Б.Бундхорол)-т тус тус даалгасугай.

3.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд (Г.Дамдинням)-д зөвлөсүгэй, Ашигт малтмал, газрын тосны газар (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Баянбаатар)-т даалгасугай.

4.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Б.Баттуяа)-т даалгасугай.

5.Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангахыг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Ц.Наранчимэг)-т даалгасугай.

6.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Санхүүгийн аудитын газрын Аудитын менежер (И.Эрдэнэцэцэг)-т үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

Үндэсний аудитын
газрын Санхүүгийн
аудитын газар

Газрын захирал,
тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг

Аудитын менежер
И.Эрдэнэцэцэг

Ахлах аудитор
Л.Нямтөмөр

Аудитор
С.Билгүтэй

Ди Эй Би Жи Аудит
ХХК

2025 оны 12 дугаар
сар
Тайланг УАГ-ын
цахим сайтаас үзнэ
үү.
www.audit.mn

Аудитын тайлан
дүгнэлттэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах,
асууж лавлах зүйл
байвал 261885,
261740 дугаарын
утсаар харилцана уу.

Хаяг:

Үндэсний аудитын
газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3
Засгийн газрын
IY байр
Улаанбаатар хот
15160
Монгол Улс

Товчилсон үгийн жагсаалт.....	2
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт.....	2-3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	4
Аудитын зорилт	4
Аудитын хамрах хүрээ	4-5
Аудитын арга зүй.....	5
Үндсэн мэдээлэл	5-6

БҮЛЭГ 1. Доншен газрын тос Монгол ХХК нь Улсын Дээд шүүхийн тогтоолоор шийдвэрлэгдсэн 2014-2018 оны баталгаажуулах аудитаар өгсөн 4,094,004.96 ам.долларын улсын төсөвт төвлөрүүлэх албан шаардлага, 2019-2021 оны баталгаажуулах аудитаар тогтоосон 981,929.53 ам.долларын төлбөрийн актыг барагдуулаагүй, Улсын Дээд шүүхийн тогтоол болон аудитын шийдвэрийг биелүүлэхгүй зөрчлийг давтан гаргасаар байна.....	7-25
1.1. АМГТГ нь гэрээлэгчийн 2022 оны ашиглалтын үйл ажиллагаа, санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, дүгнэсэн боловч тайлагнах заавар журамгүйгээс иж бүрэн, асуудлыг шийдвэрлэсэн дүгнэлтийг ирүүлэхгүй байна.....	7-21
1.2. АМГТГ нь гэрээлэгчийн Газрын тосны тухай хууль болон БХГ-ний дагуу төлөх төлбөр хураамж, урамшууллын тооцоог дүгнээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.....	21-25
БҮЛЭГ 2. АМГТГ нь Петроматад ХХК-ийн санхүүгийн тайлан, тодруулгыг хянаж хүлээж авсан ч хяналт шалгалт хийсэн талаарх нотлох баримтын бүрдэл хангалтгүй байна. 2.1. АМГТГ нь гэрээлэгчийн 2022 оны санхүүгийн тайланд хайгуул үнэлгээний хөрөнгийг 2,939,136,957.51 төгрөгөөр нэмэгдүүлэн тайлагнасныг газрын тосны бүртгэл, тооцооны журамд нийцүүлж, дүгнээгүй байна.....	25-36
2.2. АМГТГ нь гэрээлэгчийн Газрын тосны тухай хууль болон БХГ-ний дагуу төлөх төлбөр хураамжийг хянасан ч бүрэн дүгнээгүй байна.....	25-35
Холбогдох байгууллагын санал.....	35-36
Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар.....	37-41
Дүгнэлт.....	42
Зөвлөмж.....	43
Хавсралт 1.....	44-45
Хавсралт 2.....	46-48
Төлбөрийн акт.....	49-51
Албан шаардлага.....	52-53
	54-61



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
АНУ	Америкийн нэгдсэн улс
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
ГТАЭТЗБ	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
ГТБТЖ	Газрын тосны бүртгэл тооцооны журам
ГӨДСГЗ	Галба-Өөш-Долоодын сав газрын захиргаа
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ӨНЗ	Өртөг нөхөгдөх зардал
СЯ	Сангийн яам
СТОУС	Санхүү тайлагналтын олон улсын стандарт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УГ	Усны газар
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

БҮЛЭГ 1	
Хүснэгт 1	АМГТГ-ын БХГ-97 талбайн 2022 оны ашиглалтын үйл ажиллагааг хянаж дүгнэсэн байдал
Хүснэгт 2	БХГ-97 талбайн 2022 онд хийх ажлын төлөвлөгөөний батлагдсан төсөв
Хүснэгт 3	БХГ-97 талбайн 2022 онд хийх ажлын төлөвлөгөөний төсвийн гүйцэтгэл
Хүснэгт 4	БХГ-97 талбайн 2022 оны газрын тосны олборлолтын төлөвлөгөөний гүйцэтгэл
Хүснэгт 5	БХГ-97 талбайн 2022 оны газрын тосны орлого, зарлагын тооцоо
Хүснэгт 6	БХГ-97 талбайн 2022 оны ус шахалтын үйл ажиллагаанд хэрэглэсэн усны тооцоо
Хүснэгт 7	БХГ-97 талбайн 2022 оны ус ашиглалтын хяналт
Хүснэгт 8	БХГ-97 талбайн 2022 оны ус ашиглалтын төлбөр тооцоо
Хүснэгт 9	БХГ-97 талбайн 2022 оны өртөг нөхөгдөх зардал
Хүснэгт 10	ӨНЗ-аас хассан зардлын ангилал
Хүснэгт 11	Өртөг нөхөгдөх зардлын баталгаажуулалт
Хүснэгт 12	БХГ-97 талбайн 2022 оны ӨНЗ-д тооцох 2019-2021 онуудын мөнгөөр төлөгдөөгүй өглөгийн тооцоо



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хүснэгт 13	БХГ-97 талбайн 2022-2023 оны өртөгт газрын тосны хувийн тооцоолол
Хүснэгт 14	БХГ-97 талбайн МУЗГ-ын хөрөнгө оруулалтын тооцоолол
Хүснэгт 15	БХГ-97 талбайн ӨНЗ-ын үлдэгдлийн тооцоолол
Хүснэгт 16	БХГ-97 талбайн 2022 онд экспортолсон газрын тос
Хүснэгт 17	БХГ-97 талбайн 2022 оны борлуулалтын зардал
Хүснэгт 18	БХГ-97 талбайн 2022 оны борлуулалтын зардлын тооцоо
Хүснэгт 19	БХГ-97 талбайн 2022 оны борлуулсан газрын тос
Хүснэгт 20	Борлуулалтын гэрээний үнийн өөрчлөлт
Хүснэгт 21	БХГ-97 талбайн 2022 оны борлуулалтын орлого
Хүснэгт 22	БХГ-97 талбайн МУЗГ-т төлөх роялти
Хүснэгт 23	БХГ-97 талбайн 2022 оны бүтээгдэхүүн хуваах тооцоо
Хүснэгт 24	БХГ-97 талбайн 2022 оны МУЗГ-т төвлөрүүлэх тосны орлогын тооцоо
Хүснэгт 25	БХГ-97 талбайн 2022 оны МУЗГ-т төвлөрүүлэх төлбөр, хураамжийн орлого
Хүснэгт 26	Аудитын шийдвэрийн хэрэгжилт
БҮЛЭГ 2	
Хүснэгт 1	Матад ХХ талбайн үйл ажиллагааны тайлан, мэдээ
Хүснэгт 2	Матад ХХ талбайн 2021.7-2023 оны ашиглалтын үйл ажиллагааны тайлан хянасан байдал
Хүснэгт 3	Санхүүгийн тайланд тусгагдсан дүн
Хүснэгт 4	Матад ХХ талбайн 2021.7-2023 онд хийх ажлын батлагдсан төсөв
Хүснэгт 5	Матад ХХ талбайн 2021.7-2023 онд хийх ажлын төлөвлөгөөний төсвийн гүйцэтгэл
Хүснэгт 6	Матад ХХ талбайн 2021.07-2023 оны нийт зардлын дүн
Хүснэгт 7	Матад ХХ талбайн 2021.7-2023 оны өртөг нөхөгдөх зардал
Хүснэгт 8	Матад ХХ талбайн 2021.7-2023 оны ӨНЗ-аас хассан зардал-Ангилал
Хүснэгт 9	Матад ХХ талбайн 2021.7-2023 оны ӨНЗ-ын баталгаажуулалт
Хүснэгт 10	Матад ХХ талбайн нийт ӨНЗ-ын баталгаажуулалт
Хүснэгт 11	Матад ХХ талбайн 2021.7-2023 онд МУЗГ-т төвлөрүүлсэн орлого
Хүснэгт 12	Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3¹-т тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2², 37 дугаар зүйлийн 37.2³, 37.3⁴ дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, МУЕА-ын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан ТАБ-ын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Газрын тосны салбарт БХГ-ээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт болон санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, БХГ-тэй нийцэж буй эсэхэд аудит хийж, баталгаажуулан аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт оршино.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- АМГТГ нь гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, БХГ-ний дагуу анхан шатны баримт материалд үндэслэн хянаж хүлээж авсан эсэх;
- Холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаж, үнэн зөв дүгнэлт тайлан ирүүлсэн эсэх;
- Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан эсэх;

Аудитын хамрах хүрээ

Аудитаар АМГТГ-аас ТАБ-д ирүүлсэн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулсан Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2022 он, Петроматад ХХК-ийн 2021-2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг хянан шалгаж, ирүүлсэн тайлан, дүгнэлтийн хүрээнд тухайн гэрээлэгчдийн анхан шатны баримт материал, санхүүгийн үйл ажиллагааг хамруулав. Үүнд:

1. АМГТГ-аас ТАБ-д 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1/5145 дугаар албан бичгээр ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн 2022 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланд хяналт, шалгалт хийсэн дүгнэлт тайлан;
2. АМГТГ болон Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн Зүүнбаян, Цагаан-Элсний ордоос 2022 онд олборлож, экспортолсон түүхий тосны тооцоог 2023 оны 3 дугаар сарын 10-ны өдөр тооцоо нийлж баталгаажуулсан протокол;
3. АМГТГ нь зөвшөөрч хүлээн авсан Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайд хийсэн газрын тосны үйл ажиллагааны 2022 оны тайлан;

¹ төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх;

² Өртөг нөхөгдөх зардлыг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулж, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан өртөгт газрын тосны хувиар нөхнө;

³ Энэ хуулийн 37.1-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, дүгнэлтэд төрийн аудитын байгууллага аудит хийж, баталгаажуулна;

⁴ Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 37.2-т заасан аудитыг гүйцэтгэхдээ хараат бус шинжээч, мэргэжилтэн, аудитын хуулийн этгээдийг оролцуулж болно.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

4. АМГТГ-аас ТАБ-д 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 1/2566, 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/494, 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн 2021-2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланд хяналт, шалгалт хийсэн дүгнэлт тайлан;
5. Холбогдох анхан шатны баримт материал.

Петрочайна Дачин Тамсаг ХХК-д өгсөн өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, тодорхой шийдэлд хүрээгүй тул Тосон Уул XIX, Тамсаг XXI гэрээт талбайн 2022, 2023 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулах боломжгүй тус тайланд нэгтгэгдээгүй болно.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4000, 4001 болон МУЕА-ын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан гэрээлэгчдийн олборлолтын талбайн батлагдсан төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөж, хууль журмын дагуу гүйцэтгэсэн эсэх, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг үнэн зөв бүртгэж тайлагнасан эсэх ажлын гүйцэтгэлийг санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн ерөнхий журнал, ерөнхий дэвтэр болон анхан шатны баримттай нь тулган баталгаажуулах горимыг хэрэгжүүлсэн.

Мөн холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тайлбар авах, батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын бодит гүйцэтгэл, АМГТГ хянан хүлээн авсан баримт материалыг хянан шалгах зэргээр нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсыг төлөөлж Газрын тосны хэрэг эрхлэх газар /хуучин нэрээр/, АНУ-ын “Нескор Энержи” компанийн хооронд 1997 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр БХГ-97 талбайд олборлолт явуулах БХГ-г байгуулсныг МУЗГ-ын 1997 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 47 дугаар тогтоолоор анх баталсан байна. Гэрээлэгч компани нь өөрийн эрх үүргийг 1999 онд Австралийн “Рок ойл (Говь)” ХХК-д шилжүүлсэн.

Рок ойл (Говь) ХХК нь “БХГ-97” талбайн гэрээлэгчийн эрх үүргийг БНХАУ-ын Доншен Жингүн Петролеум Групп Сток компанид 2001 онд хэсэгчлэн, 2003 онд бүрэн шилжүүлсэн байна.

Доншен Жингүн Петролеум Групп Сток компани нь 2003 онд Монгол Улсад өөрийн салбар Доншен газрын тос Монгол ХХК-ийг байгуулж, БХГ-нд заасан газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд 2011 оноос эхлэн уг талбайг ашиглалтад шилжүүлсэн байна.

БХГ-97 талбай нь Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн нутаг дэвсгэрт байршдаг бөгөөд нийт ашиглалтын талбай 239.5 м² байна. Тус талбайн баталгаат нөөц 186.1 сая баррель (26.02 сая.тн) ба гарч буй газрын тосны үзүүлэлт 878 кг/м³, 0.12 хувь хүхэр, 29.6 мПа*с буюу өтгөн чанарын үзүүлэлттэй байна.

Тус компани 2003 оноос хойш нийт 1,038 сая.тонн газрын тос олборлосон бөгөөд үүнээс Доншен газрын тос Монгол ХХК нь БХГ-ний дагуу 134.0 сая.ам долларыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Доншен газрын тос (Монгол) ХХК нь БХГ-97 талбайгаас 2022 онд нийт 96.9 мянган баррель тос экспортолж, 8.3 сая ам.долларын борлуулалтын орлого тайлагнасан. Үүнээс МУЗГ-т 503.6 мянган ам.долларын газрын тосны нөөц ашигласны төлбөр, 20.7 мянган ам.долларын өртөгт газрын тос, 1.4 сая ам.долларын ашигт газрын тос, нийт 1.9 сая ам.долларын орлого ногдох тухай тайлагнаж, төлөлтүүдийг хийсэн байна.

Газрын тосны хэрэг эрхлэх газар /хуучин нэрээр/ болон Петроматад ХХК-ний хооронд Дорнод аймгийн нутаг дэвсгэрт орших газрын тосны хайгуулын Матад ХХ талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах тухай БХГ-г 2006 оны 5 дугаар сарын 26-ны өдөр байгуулж, МУЗГ-ын 2006 оны 7 дугаар сарын 19-ний өдөр 170 дугаар тогтоолоор баталсан байна.

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2014 онд батлагдаж, МУЗГ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолын дагуу БХГ-г 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдөр шинэчлэн байгуулсныг мөрдөж байна.

Гэрээлэгч нь 2019 онд нээлтийн цооногоо бүртгүүлж, газрын тосны нөөцийн тооцооны тайланг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Үүний дагуу УУХҮС-ын 2021 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн А/36 дугаар тушаалаар Цэн тогоруу ордын газрын тосны нөөцийг баталгаат зэрэглэлээр 1.15 сая.тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137.9 мянган тонноор ашигт малтмалын нэгдсэн санд бүртгэсэн байна.

Аудитад учирсан хүндрэл бэрхшээл

Үндэсний аудитын газраас Доншен газрын тос (Монгол) ХХК нь “БХГ-97” гэрээт талбайн өртөг нөхөгдөх зардлыг тайлагнахдаа бүтээн байгуулалтын зардалд хамаарах Зүүнбаян танкфармын боловсруулалтын төвийн өртөг гэсэн зардлыг борлуулалтын зардалд оруулж тооцсон нь “БХГ-97”-ийн 8.2.б-д “Гэрээлэгч нь газрын тосны үйл ажиллагаатай холбогдолтой бүх өртөг зардлыг хайгуулын зардал, бүтээн байгуулалтын зардал ба үйл ажиллагааны зардал гэж давхардуулахгүйгээр ангилна...”, 8.4.в-д “...экспортын үнийг тогтоохдоо тухайн цэгээс гэрээт түүхий тосыг бодитойгоор нийлүүлэх цэг хүртэлх бүх зардлыг хасаж тооцно...” гэж заасантай нийцэхгүй гэж үзэн 2014-2018 онд 4.0 сая ам.долларыг улсын төсөвт төвлөрүүлэх албан шаардлага өгснийг Нийслэл дэх Захиргааны анхан, давж заалдах, Улсын Дээд шүүхийн тогтоолоор хэвээр үлдээсэн тул 2019-2021 онд 0.9 сая /981,929.53/ ам.долларын төлбөрийн актын нэмж тогтоосон боловч өнөөг хүртэл биелүүлэхгүй, асуудлыг шийдвэрлэхгүй, ТАБ-ын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд саад учруулж байна.

Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2019-2021 оны ӨНЗ-н тайланд хийсэн баталгаажуулах аудитын дүн дүгнэлт, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж, гэрээний 2 тал асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахгүй байгаа нь Төрийн аудитын байгууллага дараагийн онуудын ӨНЗ-н тайланг баталгаажуулах боломжгүй болж, хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл үүсэж байна.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

БҮЛЭГ 1. ДОНШЕН ГАЗРЫН ТОС МОНГОЛ ХХК НЬ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛООР ШИЙДВЭРЛЭГДСЭН 2014-2018 ОНЫ БАТАЛГААЖУУЛАХ АУДИТААР ӨГСӨН 4,094,004.96 АМ.ДОЛЛАРЫН УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ АЛБАН ШААРДЛАГА, 2019-2021 ОНЫ БАТАЛГААЖУУЛАХ АУДИТААР ТОГТООСОН 981,929.53 АМ.ДОЛЛАРЫН ТӨЛБӨРИЙН АКТЫГ БАРАГДУУЛААГҮЙ, УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ БОЛОН АУДИТЫН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХГҮЙ ЗӨРЧЛИЙГ ДАВТАН ГАРГАСААР БАЙНА.

1.1. АМГТГ НЬ ГЭРЭЭЛЭГЧИЙН 2022 ОНЫ АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЯНАЖ, ДҮГНЭСЭН БОЛОВЧ ТАЙЛАГНАХ ЗААВАР, ЖУРАМГҮЙГЭЭС ИЖ БҮРЭН, АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ДҮГНЭЛТИЙГ ИРҮҮЛЭХГҮЙ БАЙНА.

1.1.1. АМГТГ НЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДҮНГ ГЭРЭЭЛЭГЧИД ТАНИЛЦУУЛЖ, ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРҮҮЛЖ, ШИЙДВЭРЛЭЭГҮЙ ДҮГНЭЛТ ИРҮҮЛЖ БАЙНА.

Гэрээлэгч нь БХГ-ний 13 дугаар зүйлийн 13.1⁵, 13.2⁶ дэх хэсэг, Хавсралт В.1.4⁷ дэх хэсэг, АМГТГ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8⁸ дахь заалт, БХГ-ний Хавсралт В.1.5⁹ дэх хэсэг, ЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан ГТБТЖ-ын 11 дүгээр зүйлийн 11.6¹⁰ дахь заалтыг тус тус хэрэгжүүлэхээр зохицуулсан байна.

Хүснэгт 1. АМГТГ-ын БХГ-97 талбайн 2022 оны ашиглалтын үйл ажиллагааг хянаж дүгнэсэн байдал

№	Үзүүлэлт	АШБ-д үндэслэсэн эсэх	Бүрэн хянаж дүгнэсэн эсэх	Хянаж дүгнэсэн байдал
1	Батлагдсан төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл	тийм	бүрэн	Гэрээлэгч нийт 28,128.5 мянган ам.долларын төсөв батлуулсан. Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийг тоо хэмжээгээр ажил тус бүрээр гарган төсөвтэй зэрэгцүүлэн хянаж дүгнэсэн.
2	Хөрөнгө оруулалт	тийм	бүрэн	МУЗГ-ын хөрөнгө оруулалтыг өссөн дүнгээр дүгнэсэн.
3	Олборлолтын үйл ажиллагаа	тийм	бүрэн	СЯ-наас борлуулах тосны төлөвлөгөөг төсвийн орлоготой уялдуулан баталж өгдөг талаар нэмэлт тайлбар өгч нотлох баримт ирүүлсэн.
			бүрэн	Газрын тосны нөөцийн хөдөлгөөнийг гэрээлэгчийн үйл ажиллагааны тайланд тайлагнасныг хянаж, нэмэлт тайлбар өгсөн.
			дутуу	АМГТГ болон гэрээлэгчийн 2023.03.10-ны өдрийн протоколд үйлдвэрлэлд хэрэглэсэн усны тооцоог гаргаж дүгнэсэн. 2022 оны ус шахалтын тайланг аудитад ирүүлээгүй, усны хөдөлгөөний тооцоог дүгнээгүй.

⁵ Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хамаарах үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг В хавсралтад заасан тооцооны журам болон олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нягтлан бодох бүртгэлийн нийтлэг зарчмуудын дагуу хөтөлнө;

⁶ ...Гэрээлэгч нь нягтлан бодох бүртгэлийн тайлан мэдээг нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу Засгийн төлөөлөгчид улирал болон жилээр гаргаж өгнө;

⁷ Гэрээлэгч нь хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн улирал бүр дууссаны дараа 60 хоногийн дотор тухайн хуанлийн улиралд явуулсан газрын тостой холбогдсон үйл ажиллагааны олборлолт, орлого, зарлагыг тусгаж дээрх үзүүлэлтүүдийг зохих ангиллаар нэгтгэн дүгнэсэн үйлдвэрлэл, өртөг нөхөлтийн тайлан мэдээг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойших байдлаар дүгнэсэн хураангуй мэдээллийн хамт Засгийн газрын төлөөлөгчид бүрдүүлж өгнө;

⁸ гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж нэгтгэх;

⁹ Засгийн газрын төлөөлөгч нь гэрээлэгчээс хүлээн авсан өдрөөс хойш 2 жилийн дотор үйлдвэрлэл болон өртөг нөхөлтийн тухайн тайлан мэдээ нэг бүрийн хувьд гэрээлэгчийн нягтлан бодох бүртгэл тооцоо, туслах баримт бичгийг шалгах эрхтэй. Гэрээлэгч нь энэ 2 жилийн хугацаанд дээрх бүртгэл тооцоо, туслах баримт бичиг буюу үйлдвэрлэл, өртөг нөхөлтийн тухай аливаа тайланд гарсан ямар ч алдааг засах эрхтэй;

¹⁰ Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь шалгалтын дүгнэлтийг гэрээлэгч эсхүл оператор компанийн саналын хамт Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

4	Өртөг нөхөгдөх зардал	тийм	бүрэн	Гэрээлэгчийн ӨНЗ-ын тайлангийн үзүүлэлтийг шалгасан дэлгэрэнгүй ажлын баримт, дүгнэлт файлыг хавсралтаар ирүүлсэн. Тайлан, дүгнэлт хэсэгт зэрэгцүүлээгүй.
			бүрэн	Өмнөх онд мөнгөөр төлөгдөөгүй өглөгийг дараах үндэслэлээр залруулаагүй байна. 2019-2021 оны аудитын тайланг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталгаажуулсан. АМГТГ-аас 2022 оны тайлан, дүгнэлтийг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1/5145 тоот албан бичгээр ирүүлсэн.
5	Газрын тосны олборлолт, экспорт, борлуулалт, бүтээгдэхүүн хуваалт	тийм	бүрэн	СЯ-наас борлуулах тосны төлөвлөгөөг төсвийн орлоготой уялдуулан баталдаг талаар нэмэлт тайлбар өгч нотлох баримт ирүүлсэн.
6	Төсөвт төвлөрүүлэх тосны орлого, төлбөр, хураамж, урамшуулал	тийм	дутуу	Төсөвт төвлөрүүлэх орлого, төлбөр, хураамж, урамшууллын бүрэн төлөгдсөн эсэх, хугацаандаа төлсөн эсэх талаар дүгнээгүй, 2 тал тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
7	Санхүүгийн тайлан, ӨНЗ-ийн тайланг уялдаатай тайлагнах	тийм	бүрэн	Тайлагналын уялдаа холбоо, тайланд тавигдах шаардлагуудын талаарх 10 зүйлийг дүгнэж, гэрээлэгчид шаардлага хүргүүлсэн.
8		тийм	дутуу	БХГ-97 талбай 2011 оноос ашиглалтад шилжсэн байна. Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2014 онд батлагдсанаас хойш гэрээлэгчийн санхүүгийн тайланд СТОУС болон ГТБТЖ-ын дагуу Газрын тосны хөрөнгө, нөөцийн хөдөлгөөний тайлантай уялдуулан тайлагнасан эсэхийг дүгнээгүй байна.

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

АМГТГ-ын даргын 2024 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Дорноговь аймгийн нутагт орших БХГ-97 талбайн 2022 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланд анхан шатны баримтад үндэслэн хяналт шалгалт хийж, УАГ-т дүгнэлт тайланг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1/5145 дугаар албан бичгээр, хавсралтаар БХГ-97 талбайн Зүүнбаян, Цагаан-Элсний ордоос 2022 онд олборлож, экспортолсон түүхий тосны тооцоо нийлж баталгаажуулсан протокол, гэрээлэгчийн АМГТГ-т ирүүлсэн БХГ-97 талбайд хийсэн газрын тосны үйл ажиллагааны 2022 оны тайланг ирүүлсэн.

АМГТГ нь дүгнэлт тайланд бараа материал, үндсэн хөрөнгө, борлуулалтын орлого, өртөг зардлын мэдээллийн өртөг нөхөгдөх зардал болон санхүүгийн тайлангийн мэдээллийг зэрэгцүүлэн оруулсан боловч 2022 оны олборлосон болон борлуулсан газрын тосны төлөвлөгөөний гүйцэтгэлийг дүгнэлт тайланд дурдаагүй, усны хөдөлгөөний тооцоо, төсөвт төвлөрүүлэх төлбөр хураамж, урамшууллын гүйцэтгэл, СТОУС болон ГТБТЖ-ын дагуу газрын тосны хөрөнгийг нөөцийн хөдөлгөөний тайлантай уялдуулан санхүүгийн тайланд тайлагнасан эсэхийг дүгнээгүй байна.

Мөн дүгнэлт тайланд өртөг нөхөгдөх зардлыг хянасан тооцооллыг гэрээлэгчийн тайлагнасан үзүүлэлттэй харьцуулж, хассан шалгуур үзүүлэлтүүдийн тайлбар, борлуулалтын зардлын тооцооллыг хавсаргаагүй байна.

АМГТГ нь гэрээлэгчийн 2022 оны Бараа материал, Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хяналтын тооллого, бүртгэл хийгээгүй нь МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ГТБТЖ-ын 4 дүгээр зүйлийн 4.3.1¹¹-т заасныг хэрэгжүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй нь ковид-19 цар тахлаас үүдэн байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулах боломжгүй болсонтой холбоотой байна.

¹¹ ГТАЭТЗБ нь гэрээлэгч, эсхүл оператор компанийн үйл ажиллагааны эд материал, биет хөрөнгө, барилга байгууламжийн тооллогыг хийнэ;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Цаашид Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8¹², БХГ-ний Хавсралт В хавсралтын 1.5¹³, ГТБТЖ-ын 11 дүгээр зүйлийн 11.1¹⁴ дэх хэсэгт заасны дагуу өртөг нөхөгдөх зардлын тайлангийн санхүүгийн анхан шатны баримтыг иж бүрэн хангалттай нотлох баримтын шаардлагад нийцүүлж бүрдүүлэх, батлагдсан төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг дүгнэхдээ шалтгаан нөхцөлийг тодорхойлох, өмнөх онд мөнгөөр төлөгдөөгүй үндэслэлээр хасагдсан өглөг болон төсөвт төвлөрүүлэх орлого, төлбөр, хураамж урамшууллыг тооцоо нийлж баталгаажуулах, хяналт шалгалтыг хийх, дүгнэх, тайлагнах нэгдсэн загвар, журамтай болох, борлуулалтын зардлыг тооцох аргачлал, журмыг боловсруулах, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг гэрээлэгчид зөвшөөрүүлж, маргаан зөрчлийг эцэслэн шийдвэрлэсэн дүгнэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлэх шаардлагатай байна.

1.1.2. АМГТГ НЬ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХДЭЭ, ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТАЙЛБАР ТОДРУУЛГЫГ ТУСГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

1.1.2.1. АУДИТААР БХГ-97 ТАЛБАЙН 2022 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ 19 ХУВЬТАЙ БУЮУ 5,344,848.86 АМ.ДОЛЛАРООР ТАЙЛАГНАСАН БАЙНА.

Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3¹⁵, 11.2.3¹⁶-т заасны дагуу БХГ-ээр ашиглаж байгаа орд газрын хайгуул, судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон газрын тосны баялаг, нөөцийг техник-эдийн засгийн болон экологийн хувьд хамгийн үр ашигтайгаар ашиглаж, олборлох талаар үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан төрийн эрх бүхий байгууллагаар батлуулах үүргийг хэрэгжүүлнэ.

Гэрээлэгч нь 2022 онд гүйцэтгэх жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулж, АМГТГ-т хүргүүлснийг 27,974,344.00 ам.доллараар баталсан. Жилийн дундуур орд ашиглалтын зардалд нэмэлт өөрчлөлт оруулан төсвийг шинэчлэн 28,128,544.00 ам.доллараар батлуулсан байна.

Хүснэгт 2. БХГ-97 талбайн 2022 онд хийх ажлын төлөвлөгөөний батлагдсан төсөв

/ам.доллар/

№	Ажлын хөтөлбөр	Гэрээлэгчээс ирүүлсэн санал	АМГТГ-аас баталсан дүн	Зөрүү	Батлагдсан нэмэлт төсөв	Тухайн оны нийт төсөв
1	Орд ашиглалт	11,330,292.00	11,330,292.00	-	154,200.00	11,484,492.00
2	Дэд бүтэц	4,613,595.00	4,613,595.00	-	-	4,613,595.00
3	Машин туслах тоног төхөөрөмжүүд	253,555.00	253,555.00	-	-	253,555.00
4	Байгаль орчин хамгаалах ажил	121,624.00	121,624.00	-	-	121,624.00
5	Аюулгүй ажиллагаа	133,970.00	133,970.00	-	-	133,970.00
6	Үйл ажиллагааны зардал	10,322,382.00	10,322,382.00	-	-	10,322,382.00
ӨНЗ-ЫН НИЙТ ДҮН		26,775,418.00	26,775,418.00	-	154,200.00	26,929,618.00
7	Сургалтын урамшуулал	60,000.00	60,000.00	-	-	60,000.00

¹² Гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж нэгтгэх;

¹³ Засгийн газрын төлөөлөгч нь гэрээлэгчээс хүлээн авсан өдрөөс хойш 2 жилийн дотор үйлдвэрлэл болон өртөг нөхөлтийн тухайн тайлан мэдээ нэг бүрийн хувьд гэрээлэгчийн нягтлан бодох бүртгэл тооцоо, туслах баримт бичгийг шалгах эрхтэй. Гэрээлэгч нь энэ 2 жилийн хугацаанд дээрх бүртгэл тооцоо, туслах баримт бичиг буюу үйлдвэрлэл, өртөг нөхөлтийн тухай аливаа тайланд гарсан ямар ч алдааг засах эрхтэй...;

¹⁴ Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3, 9.1.8, 9.1.10, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, зарцуулсан зардал, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, төлбөр урамшууллын төлөлт, борлуулсан газрын тосны орлогын тооцоог үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавьж ажиллана.

¹⁵ шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны байгууллагын зөвшөөрснөөр жилийн төлөвлөгөө, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах;

¹⁶ жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

8	Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг	30,000.00	30,000.00	-	-	30,000.00
9	Орон нутгийн хөгжлийн сан төлсөн мөнгө	40,000.00	40,000.00	-	-	40,000.00
10	Тусгай зөвшөөрлийн төлбөр	11,975.00	11,975.00	-	-	11,975.00
11	Удирдлагын зардал	150,000.00	150,000.00	-	-	150,000.00
12	УБ оффисын зардал	906,951.00	906,951.00	-	-	906,951.00
	Өртөг нөхөгдөхгүй зардал/төлбөр, урамшуулал, бусад	1,198,926.00	1,198,926.00	-	-	1,198,926.00
	НИЙТ ДҮН	27,974,344.00	27,974,344.00	-	154,200.00	28,128,544.00

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол)-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Гэрээлэгч нь 2022 онд гүйцэтгэх жилийн ажлын төлөвлөгөөний төсвийн гүйцэтгэлийг 6,309,432.99 ам.доллар буюу 22 хувьтай тайлагнасан байна.

АМГТГ-ын хяналт шалгалтаар гэрээлэгчийн 2022 оны ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг 8,201,834.29 ам.доллар буюу 29 хувиар тооцож, төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангалттай эсэхийг дүгнээгүй, шалтгаан нөхцөлийг тодорхойлж дүгнэлт тайланд тусгаагүй байна.

Хүснэгт 3. БХГ-97 талбайн 2022 онд хийх ажлын төлөвлөгөөний төсвийн гүйцэтгэл

/ам.доллар/

№	Ажлын хөтөлбөр	Төсөв 2022 он	Гүйцэтгэл 2022 он			Гүйцэтгэлийн зөрүү	
			Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч-АМГТГ	АМГТГ-Аудит
1	Орд ашиглалт	11,484,492.00	1,334,206.66	334,125.52	334,125.52	1,000,081.14	-
2	Дэд бүтэц	4,613,595.00	368,262.34	67,448.17	53,578.35	300,814.17	13,869.82
3	Машин, туслах тоног төхөөрөмжүүд	253,555.00	-	81,171.27	-	(81,171.27)	81,171.27
4	Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх	121,624.00	44,096.40	26,685.09	19,087.04	17,411.31	7,598.05
5	Аюулгүй ажиллагаа,	133,970.00	37,859.07	10,733.28	10,733.28	27,125.79	-
6	Үйл ажиллагааны зардал	10,322,382.00	4,525,008.52	4,144,061.38	4,248,414.89	380,947.14	104,353.51
	ӨНЗ-ын нийт дүн	26,929,618.00	6,309,432.99	4,664,224.71	4,665,939.08	1,645,208.28	(1,714.37)
7	Төлбөр, урамшуулал	1,198,926.00	-	-	-	-	-
	Өртөг нөхөгдөхгүй зардал/төлбөр, урамшуулал, бусад	1,198,926.00	-	-	-	-	-
8	Өмнөх оны төлөвлөгөө, төсөв дэх ажилд зарцуулсан дүн	-	-	3,537,709.58	678,909.78	(3,537,709.58)	2,858,799.80
	НИЙТ ДҮН	28,128,544.00	6,309,432.99	8,201,934.29	5,344,848.86	(1,892,501.30)	2,857,085.43

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол)-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Аудитаар төсвийн гүйцэтгэлийг гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлын тайланд үндэслэн шалгаж 5,344,848.86 ам.доллараар тооцон, гэрээлэгчийн ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг 19 хувьтай гэж дүгнэлээ.

БХГ-97 талбайн 2022 онд хийх ажлын төлөвлөгөөний төсвийн гүйцэтгэл АМГТГ-ын дүгнэснээс 2,857,085.43 ам.долларын зөрүүтэй байгаа нь өмнөх оны төлөвлөгөө, төсөв дэх



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

ажилд зарцуулсан өглөгийн тооцоололтой холбоотой байна. /дэлгэрэнгүйг хүснэгт 12-оос үзнэ үү./

1.1.2.2. АМГТГ БХГ-97 ТАЛБАЙН ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ, БОРЛУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, УС АШИГЛАЛТЫН ЗӨРҮҮГ ТОДОРХОЙЛОХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3¹⁷-т заасны дагуу БХГ-97 талбайн 2022 онд олборлох газрын тосны төлөвлөгөө, 11.2.13¹⁸-т заасны дагуу тосны нөөцийн хөдөлгөөний тооцоог 2022 оны үйл ажиллагааны тайланд, 11.2.16¹⁹-д заасны дагуу олборлолтын үйл ажиллагааны өдөр тутмын мэдээг цахим хэлбэрээр улирал бүрээр тайлагнаж, төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. БХГ-97 талбайн 2022 оны газрын тосны олборлолт

/баррель/

Огноо	Гэрээлэгч				АМГТГ-ын дүгнэлт	Аудитаар
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь		
2022	388,209.4	61,296.1	(326,913.3)	15.8	61,296.1	61,296.1

Эх сурвалж: Гэрээлэгч болон АМГТГ-ын БХГ-97 талбайгаас 2022 онд олборлосон хий, тос, усны тооцоог баталгаажуулсан 2023.03.10-ны өдрийн протокол

Гэрээлэгч нь 2022 онд БХГ-97 талбайд 388,209.4 баррель газрын тос олборлохоор төлөвлөснөөс 61,296.1 баррель тос олборлож, 15.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

АМГТГ-ын 2022 оны гүйцэтгэлийн тайланд тус онд ковид-19 цар тахлаас үүдэн БНХАУ хилээ хааж, эхний хагас жилийн олборлолт, экспортын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон нь борлуулалт буурч, төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байх үндсэн шалтгаан болсон гэж тайлагнасан байна.

АМГТГ болон гэрээлэгчийн БХГ-97 талбайн 2022 оны "Хий, тос, усны олборлолт, ачилт буулгалтын хэмжээг баталгаажуулсан протокол"-ын 1 дүгээр хавсралтад тоног төхөөрөмж суурилуулсан олборлолтын цооногуудаар 61,296.1 баррель газрын тос олборлосныг тэмдэглэн баталгаажуулсан байна.

Аудитаар олборлосон тосны өдөр тутмын мэдээнүүдийг сар, жилийн дүнгээр, цооног тус бүрийн олборлолтыг өссөн дүнгээр нь нэгтгэж шалгахад олборлосон тос 61,296.1 баррель байна.

Хүснэгт 5. БХГ-97 талбайн 2022 оны газрын тосны орлого, зарлагын тооцоо

/баррель/

Үзүүлэлт	2022.01.01-ний үлдэгдэл	Олборлолт	Ачилт	Буцаж ирсэн тос	2022.12.31-ний үлдэгдэл	Зөрүү
Тухайн үеийн хэмжилт	125,475.7	61,296.1	95,764.6	94.0	90,370.7	730.6

Эх сурвалж: Гэрээлэгч болон АМГТГ-ын БХГ-97 талбайгаас 2022 онд олборлосон хий, тос, усны тооцоог баталгаажуулсан 2023.03.10-ны өдрийн протокол

АМГТГ болон гэрээлэгчийн 2022 оны "Хий, тос, усны олборлолт, ачилт буулгалтын хэмжээг баталгаажуулсан протокол"-ын 4 дүгээр хавсралтад тос хадгалах саванд 50,435.7 баррель, танкфармад 39,935.0 баррель, нийт 90,370.7 баррель тосны эцсийн үлдэгдлийг хэмжиж баталгаажуулсан. Протоколын 6 дугаар хавсралтаар 2022 оны Газрын тосны орлого, зарлага, үлдэгдлийн тооцоог хийж, жилийн эцэст байх ёстой тосны үлдэгдлээс хэмжиж баталгаажуулсан тосны үлдэгдэл 730.6 баррель тосоор зөрүүтэй байгааг баталгаажуулсан байна.

¹⁷ жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх;

¹⁸ газрын тосны нөөцийн хөдөлгөөний тооцоог жил бүр гаргаж, төрийн захиргааны байгууллагаар хянуулах;

¹⁹ үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулалт, өмчлөлтэй холбоотой аливаа мэдээллийг Засгийн газрын хүсэлтээр гарган өгөх.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Дээрх зөрүүг хадгалалт, тээвэрлэлт, шилжүүлэн ачилт, буулгалт, халаалтын үеийн хэвийн хорогдол, хэмжилтийн нарийвчлал зэргээс үүссэн. Олборлолт экспортын зөрүү 730.6 баррель буюу нийт орлогын 0.39 хувь байна гэж дүгнэсэн.

АМГТГ болон гэрээлэгчийн 2022 оны протоколд газрын тосны орлого, зарлага, үлдэгдлийг зөвхөн тухайн үеийн хэмжилтээр тооцоог хийж протоколд баталгаажуулсан нь ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа бусад талбайн дүгнэлтээс өөр байна.

Энэ талаар газрын тосны шинжээчээс тодруулахад “БХГ-97” талбайн ашиглалтын цооногууд танкфарм байгууламжтай холбогдсон тул давхаргын даралтаар олборлох шаардлагагүй, мөн эзлэхүүний аргаар хэмжилт хийдэг тул ASTM-54A хүснэгтийг ашиглах шаардлагагүй гэж дүгнэсэн.

АМГТГ-аас “БХГ-97 талбайн Зүүнбаян болон Цагаан-Элсний ордуудын хувьд олборлосон тосны хэмжилт болон экспортод гаргах тосны хэмжилтийг эзлэхүүний аргаар гүйцэтгэдэг тул тонн/баррелийн харьцаа буюу жин, эзлэхүүнийг шилжүүлэн тооцох ASTM-54A хүснэгтийг ашиглах шаардлагагүй” гэсэн тайлбар ирүүлсэн байна.

Ус ашиглалтын тооцоо:

Гэрээлэгч болон АМГТГ-ын БХГ-97 талбайн 2022 оны "Хий, тос, усны олборлолт, ачилт буулгалтын хэмжээг баталгаажуулсан протокол"-ын 3 дугаар хавсралтад ус шахалтын үйл ажиллагаанд хэрэглэсэн 172,428.0 м3 усны тооцоог нийт дүнгээр баталгаажуулсан байна. Протоколд жилийн эцэст цооногууд болон байгууламжид байгаа усны үлдэгдлийг хэмжээгүй, усны орлого, зарлага, үлдэгдлийн тооцоог баталгаажуулаагүй, хэрэглэсэн усны тооцоо нь нэхэмжлэхийн дүнгээс зөрүүтэй байгаад тодруулга байхгүй байна.

Хүснэгт 6. БХГ-97 талбайн 2022 оны ус шахалтын үйл ажиллагаанд хэрэглэсэн усны тооцоо

/м3/

Огноо	ГЭРЭЭЛЭГЧ-ПРОТОКОЛЫН ХАВСРАЛТ №4				АУДИТ-УСНЫ НЭХЭМЖЛЭХЭЭР				ЗӨРҮҮ
	Цагаан элс орд-худаг	Зүүнбаян орд-худаг	Танк фарм	Нийт хэрэглэсэн ус	Цагаан элс орд-худаг	Зүүнбаян орд-худаг	Танк фарм	Нийт хэрэглэсэн ус	
2022	63,416.00	63,321.00	45,691.00	172,428.00	87,564.00	117,326.00	26,490.00	231,380.00	(58,952.00)

Эх сурвалж: Гэрээлэгч болон АМГТГ-ын БХГ-97 талбайгаас 2022 онд олборлосон хий, тос, усны тооцоог баталгаажуулсан 2023.03.10-ны өдрийн протокол

Усны газрын даргын 2022 оны 01/510 албан тоот албан бичгээр ГӨДСГЗ-д Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн Зүүнбаян дахь газрын тос олборлох үйл ажиллагаанд Ус ашиглуулах дүгнэлтийг хүргүүлсэн байна. ГӨДСГЗ-ны даргын 2022 оны А/22 тушаалаар Доншен газрын тос (Монгол) ХХК-д дээрх дүгнэлтэд заасан эх үүсвэрээс 380,357.0 м3 усыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг зөвшөөрч, гэрээлэгчтэй 2022/11 дугаартай ус ашиглах гэрээг байгуулан 2022 оны газрын тосны олборлох үйл ажиллагаанд мөрдсөн байна.

Аудитаар АМГТГ-аас гэрээлэгчийн 2022 оны ус шахалтын өдөр тутмын бүртгэл, мэдээллийг ирүүлээгүй учир Зүүнбаян дахь БХГ-97 талбайн газрын тос олборлох технологид ашиглаж буй усны төлбөр тооцооны нэхэмжлэхээс байгууламж, худгийн байршлаар нь ангилан нэгтгэж нийт хэрэглэсэн усны тооцоог гаргасан. Усны нэхэмжлэхээр Цагаан элсний орд газрын усны худгаас 87,564 м3 ус, Зүүнбаянгийн орд газрын усны худгаас 117,326.0 м3 ус, танкфармаас буцаан шахалтаар 26,490 м3 ус, нийт 231,380.0 м3 ус хэрэглэсэн нь протоколын дүнгээс 58,952.0 м3 нэгжээр их байна.

Иймд Доншен газрын тос (Монгол) ХХК болон ГӨДСГЗ хооронд ус ашиглах гэрээг дүгнэх, сар бүрийн хэрэглэсэн усны тооцооны акт үйлдэхэд АМГТГ-ын төлөөлөл байлцаж, усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ус ашиглалтын зөрүүтэй тооцоо бүртгэлийг арилгах санал шаардлага хүргүүлж ажиллах албан шаардлага өглөө.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хүснэгт 7. БХГ-97 талбайн 2022 оны ус ашиглалтын хяналт

/м3/

Сар бүрийн нэхэмжлэхээр								Ус ашиглах гэрээ дүгнэх акт	Зөрү ү
Он	Чөлөөлөгдөх ус			Төлбөр тооцсон ус			Нийт		
	Цагаан элс орд-худаг	Зүүнбаян орд-худаг	Танк фарм	1954-р худаг	Биологи йн нөхөн сэргээлт	Баазын хашаа-2 /Биологи/			
2022	87.564.00	117.326.00	22.582.00	10.835.00	9.137.00	6.518.00	26.490.00	26.490.00	-

Эх сурвалж: Гэрээлэгч болон АМГТГ-ын БХГ-97 талбайгаас 2022 онд олборлосон хий, тос, усны тооцоог баталгаажуулсан 2023.03.10-ны өдрийн протокол

ГӨДСГЗ-аас 2023.02.14-ний өдөр гэрээлэгчийн 2022 оны Ус ашиглах гэрээг дүгнэж, акт үйлдсэн байна.

Хүснэгт 8. БХГ-97 талбайн 2022 оны ус ашиглалтын төлбөр тооцоо

/м3/

Огноо	Нэхэмжлэхээр -Ус /м3/					Төлбөр /төг/	Төлсөн /төг/	
	1954-р худаг	Биологийн нөхөн сэргээлт	Баазын хашаа-2 /Биологи/	Төлбөрөөс чөлөөлөгдсөн ус	Нийт ус		Дүн	Огноо
2022.01	330	-	1,588	19,351	21,269	430,806.00	430,806.00	2022.01.25
2022.02	621	-	1,184	20,439	22,244	680,787.00	680,787.00	2022.02.24
2022.03	771	-	775	25,085	26,631	795,189.00	795,189.00	2022.03.28
2022.04	1,137	-	394	20,613	22,144	1,118,751.00	1,118,751.00	2022.04.25
2022.05	1,928	-	566	17,767	20,261	1,889,704.00	1,889,704.00	2022.05.26
2022.06	971	1,730	593	15,665	18,959	1,098,445.00	1,098,445.00	2022.06.28
2022.07	488	1,978	641	10,391	13,498	656,560.00	656,490.00	2022.07.26
2022.08	629	1,183	511	8,351	10,674	725,179.00	725,179.00	2022.08.25
2022.09	532	2,109	266	20,770	23,677	681,188.00	681,188.00	2022.09.26
2022.10	51	896	-	22,909	23,856	113,421.00	113,421.00	2022.10.25
2022.11	1,672	889	-	24,997	27,558	1,667,456.00	1,667,456.00	2022.11.25
2022.12	1,705	352	-	21,134	23,191	1,660,439.00	1,660,439.00	2022.12.23
Дүн	10,835	9,137	6,518	227,472	253,962	11,517,925.00	11,517,855.00	

Эх сурвалж: Гэрээлэгч болон АМГТГ-ын БХГ-97 талбайгаас 2022 онд олборлосон хий, тос, усны тооцоог баталгаажуулсан 2023.03.10-ны өдрийн протокол

Аудитаар усны нэхэмжлэхийн дүнг гэрээлэгчийн төлбөр төлсөн ваучер болон банкны анхан шатны баримттай тулган шалгаж, ус ашиглалтын төлбөрийн тооцоог шалгасан. Гэрээлэгчийн Зүүнбаян дахь 2022 оны "Ус ашигласны төлбөр хийх тухай акт"-аар газрын тос олборлох технологид ашигласан нийт 253,962.0 м3 ус, үүнээс 227,472.0 м3 ус төлбөрөөс чөлөөлөгдөж, 26,490.0 м3 усны төлбөр 11,517.9 мянган төгрөг төлөх нэхэмжлэхээр 11,517.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

АУДИТААР БХГ-97 ТАЛБАЙН 2022 ОНЫ ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫГ 5,665.5 МЯНГАН АМ.ДОЛЛАРООР БАТАЛГААЖУУЛАВ.

Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.31²⁰, 32 дугаар зүйлийн 32.1²¹, 32.2²², БХГ-ний 4 дүгээр зүйлд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх өртөг, зардлыг гэрээлэгч хариуцаж, БХГ-д заасан өртөгт газрын тосны хувиар нөхөн авахаар, мөн гэрээний "В" хавсралт буюу тооцооны журамд гэрээлэгч болон хувь нийлүүлэгчийн нөхөн авах өртөг зардлын нэр төрлийг баталсан байна.

Гэрээлэгч 2022 онд 6,309,432.99 ам.долларын өртөг нөхөгдөх зардал тайлагнасныг АМГТГ-ын хяналт шалгалтаар БХГ болон холбогдох хууль тогтоомжид нийцээгүй 1,888,667.59 ам.долларыг хасаж, ӨНЗ-ыг 4,420,765.40 ам.доллороор хянасан.

²⁰ "өртөг нөхөгдөх зардал" гэж хайгуул, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, татан буулгалтын зардлын нийлбэрийг;

²¹ Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зардлыг гэрээлэгч хариуцна;

²² Өртөг нөхөгдөх зардлыг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулж, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан өртөгт газрын тосны хувиар нөхнө.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хүснэгт 9. БХГ-97 талбайн 2022 оны өртөг нөхөгдөх зардал

/ам.доллар/

Он	ӨНЗ			Зөрүү	
	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч-АМГТГ	АМГТГ-Аудит
2022	6,309,432.99	4,420,765.40	4,414,104.69	1,888,667.59	6,660.71
Дүн	6,309,432.99	4,420,765.40	4,414,104.69	1,888,667.59	6,660.71

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Аудитаар гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлын тайлангийн ажил гүйлгээг мөнгөөр төлөгдсөн эсэх, мөнгөн хөрөнгийн журналд бүрэн тайлагнасан эсэх, анхан шатны баримтын бүрдэл хангасан эсэх, ажлын төлөвлөгөө, төсөвт тусгагдаж бүрэн гүйцэтгэсэн эсэхийг тулган шалгаж 4,414,104.69 ам.доллар буюу АМГТГ-ын хянасан дүнгээс 6,660.71 ам.доллараар бууруулан тооцлоо.

Хүснэгт 10. ӨНЗ-аас хассан зардлын ангилал

/ам.доллар/

№	Хасагдсан зардлын ангилал	АМГТГ	Аудит	Зөрүү /АМГТГ-Аудит/
1	Мөнгөөр төлөөгүй буюу өглөг	1,099,736.15	1,099,736.15	-
2	Захиргааны зардал	74,599.42	85,128.46	(10,529.04)
3	Анхан шатны баримтын бүрдэл дутуу	312,982.85	307,010.02	5,972.83
4	И-баримтгүй	-	1,911.45	(1,911.45)
5	Татвар, торгууль, хураамж	786,037.88	453,271.55	332,766.33
6	Хандив, бэлэг, тусламж	-	311,950.07	(311,950.07)
7	Тосны цалин (нэмсэн)	(384,688.71)	(363,679.40)	(21,009.31)
Дүн		1,888,667.59	1,895,328.30	(6,660.71)

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын тайланг БХГ-ний хавсралт В “Нягтлан бодох бүртгэлийн тооцооны журам”, МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан ГТБТЖ-д нийцүүлэн шалгаж дараах ангиллуудын дагуу өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй 1,895,328.30 ам.долларыг хасаж тооцсон.

YAГ-ын байгаль орчны шинжээчийн дүгнэлтээр ZB217, ZB261, ZB114, ZB85, ZB220 дугаартай цооногуудын 655.98 ам.долларын ажил анхан шатны баримтаар нотлогдоогүй, ZB74, ZB108, ZB72, ZB64, SWZB315 цооногуудын 2022 оны 5-10 дугаар сард хийгдсэн 791.14 ам.долларын ажлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, 2022 оны 5-р сард хийсэн гэрээний дагуу 6,150.93 ам.доллар урьдчилгаа төлбөр хийгдсэн ч ажлаа гүйцэтгээгүй үндэслэлээр Байгаль орчныг хамгаалах ажлын гүйцэтгэлээс нийт 7,598.05 ам.долларын зардлыг хасаж тооцоолсон.

Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3²³, БХГ-ний 8 дугаар зүйлийн 8.2-т гэрээлэгч нь гэрээт түүхий тосны 40 хувийн өртөгт тосыг авч зарцуулах бөгөөд нөхөж аваагүй үлдсэн бүх өртөг зардал нь дараа дараагийн хуанлийн саруудад бүрэн нөхөж дуустал шилжин тооцогдох, хэрэв БХГ дуусгавар болох үед ӨНЗ-аас нөхөгдөөгүй бол үлдсэн хэсгийг гэрээлэгчид олгохгүй байх зохицуулалттай.

АМГТГ нь гэрээлэгчийн тайлагнасан 6,309,432.99 ам.долларын өртөг нөхөгдөх зардлаас ГТБТЖ-ын холбогдох заалтад нийцээгүй 1,888,667.59 ам.долларын зардлыг хасаж, борлуулалтын зардлаас хассан 243,459.32 ам.доллар, өмнөх оны өглөгөөс мөнгөөр төлөгдсөн 3,537,709.58 ам.долларын зардлыг тус тус нэмж тооцсон байна. Эх компанийн захиргааны нэмэгдэл зардлыг БХГ-ний В хавсралтын 2.1.к.1-н дагуу тооцоолсон өртөг нөхөгдөх зардлын 6.0 хувиар тооцон 492,116.06 ам.долларыг нэмэгдүүлэн, 8,694,050.36 ам.доллараар нийт өртөг нөхөгдөх зардлыг дүгнэсэн байна. Тайлант жилд өртөгт тосоор өртөг нөхөгдсөн зардал 3,100,424.02 ам.доллар байна.

²³ Өртөгт газрын тосны хэмжээ нь тухайн жилд олборлосон нийт газрын тосноос нөөц ашигласны төлбөрт ногдох газрын тосыг хасаад үлдэх тосны 40 хүртэл хувь байх ба уламжлалт бус газрын тосны хувьд энэ хуульд заасан холбогдох журмын дагуу зохицуулна;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

БХГ-ний Хавсралт В.2.1.к.¹²⁴-д заасны дагуу гэрээлэгч захиргааны зардлыг 6.0 хувиар тооцоолон тайлагнаж байгаа нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6²⁵-д заасантай нийцээгүй хэвээр байна.

Хүснэгт 11. Өртөг нөхөгдөх зардлын баталгаажуулалт

/ам.доллар/

Хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардал	Тайлагнасан	Хянасан		Зөрүү	
	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч-АМГТГ	АМГТГ-Аудит
Өртөг нөхөгдөх зардал /тайлангаар/	6,309,432.99	6,309,432.99	6,309,432.99	-	-
Хяналт, шалгалтаар хасагдсан дүн	-	1,888,667.59	1,895,328.30	1,888,667.59	(6,660.71)
Тос борлуулалттай холбогдох зардлаас шилжүүлсэн дүн	-	243,459.32	243,459.32	243,459.32	-
Өмнөх оны өглөгөөс төлөгдсөн өнз-д тооцох дүн	-	3,537,709.58	678,909.78	3,537,709.58	2,858,799.80
Өртөг нөхөгдөх зардлын дүн	6,309,432.99	8,201,934.30	5,336,473.79	1,892,501.31	2,865,460.51
Захиргааны зардал 6%	378,565.98	492,116.06	320,188.43	113,550.08	171,927.63
Дүн	6,687,998.97	8,694,050.36	5,656,662.22	2,006,051.39	3,037,388.14
Тухайн жилд өртөгт тосоор нөхөгдсөн дүн	2,664,977.39	3,100,424.02	3,101,110.65	435,446.63	(686.63)
Өртөг нөхөгдөх зардлын нийт дүн	4,023,021.58	5,593,626.34	2,555,551.57	1,570,604.76	3,038,074.77

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Аудитаар гэрээлэгчийн ГТБТЖ-ын холбогдох заалтад нийцээгүй 1,895,328.30 ам.долларын зардлыг хасаж, борлуулалтын зардлаас хассан 243,459.32 ам.доллар, өмнөх оны өглөгөөс мөнгөөр төлөгдсөн 678,909.78 ам.долларын зардлыг тус тус нэмж тооцоолсон. Эх компанийн захиргааны нэмэгдэл зардлыг БХГ-ний дагуу 6.0 хувиар тооцон 320,188.43 ам.долларыг нэмэгдүүлэн 5,656,662.22 ам.доллороор нийт өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулсан нь АМГТГ-ын дүгнэлтээс 3,037,388.14 ам.долларын зөрүүтэй байгаа нь өмнөх оны аудитаар баталгаажуулсан дүнг гэрээлэгчийн ӨНЗ-н тайланд тохируулга хийгээгүйтэй холбоотой байна. Үүнд:

Хүснэгт 12. БХГ-97 талбайн 2022 оны ӨНЗ-д тооцох 2019-2021 онуудын мөнгөөр төлөгдөөгүй өглөгийн тооцоо

/ам.доллар/

№	Огноо	АМГТГ		Аудит		Зөрүү (АМГТГ-Аудит)	
		Хассан	Тооцсон	Хассан	Тооцсон	Хассан	Тооцсон
1	2019	4,844,203.87	-	5,234,421.80	4,178,912.11	390,217.93	4,178,912.11
2	2020	1,171,913.29	-	1,182,369.43	783,059.70	10,456.14	783,059.70
3	2021	1,447,670.22	-	1,587,223.94	769,426.50	139,553.72	769,426.50
4	2022	-	3,537,709.58	-	678,909.78	-	(2,858,799.80)
	Нийт дүн	7,463,787.38	3,537,709.58	8,004,015.17	6,410,308.09	540,227.79	2,872,598.51

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

АМГТГ нь гэрээлэгчийн 2019-2021 онуудад тайлагнасан ӨНЗ-аас мөнгөөр төлөгдөөгүй нийт 7,463,787.38 ам.долларын зардлыг хассанаас 2022 оны ӨНЗ-д 3,537,709.58 ам.долларын өглөгийг тооцсон нь АМГТГ-ын хяналт шалгалтын тайлан дүгнэлт, өмнөх аудитын тайлан баталгаажихаас өмнө ирүүлсэн тул тохируулга хийгдээгүй байна.

Аудитаар гэрээлэгчийн 2019-2021 онуудад тайлагнасан ӨНЗ-аас төлбөр төлөгдөөгүй нийт 8,004,015.17 ам.долларын зардал хассан. Аудитын явцын хяналтаар ажлын төлөвлөгөө төсөвт тусгагдсан тухайн жилд мөнгөөр төлөгдөөгүй зардлыг дараагийн

²⁴ Гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад гэрээлэгчийн эх компанийн удирдах ажилтнуудын захиргааны зардал нь газрын тостой холбогдох гэрээлэгчийн жилийн нийт зардлын 6 хувиар тооцно...;

²⁵ Гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын тав хүртэл хувь байна.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

жилүүдэд төлөгдсөн үед тооцох, санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнасан эсэхийг хянаж 2019 онд 4,178,912.11 ам.доллар, 2020 онд 783,059.70 ам.доллар, 2021 онд 769,426.50 ам.доллар, нийт 5,731,398.31 ам.долларын зардлыг тухайн онуудын ӨНЗ-д нэмж тооцсон. Дээрх шалгуурт нийцүүлэн 2022 онд төлөгдсөн 678,909.78 ам.долларын өглөгийг ӨНЗ-д нэмж тооцлоо.

АМГТГ нь тухайн жилийн аудитаар өмнөх оны мөнгөөр төлөгдөөгүй өглөгийн тооцооны дагуу гэрээлэгчийн зардлыг ижил дүнгээр тохируулан залруулж байх нь зүйтэй байна.

БХГ-ний 12 дугаар зүйлийн 12.2.6²⁶-д заасны дагуу гэрээлэгч нь тухайн жилийн нийт хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй тооцоолол, тайланг гаргаж ирүүлснийг АМГТГ хянаж, дүгнэнэ.

Хүснэгт 13. БХГ-97 талбайн 2022-2023 оны Өртөгт газрын тосны хувийн тооцоолол

/ам.доллар/

№	Өртөг нөхөлтийн хувийн тооцоолол		АМГТГ		Аудит		Зөрүү /Аудит-АМГТГ/
			Дүн	Хувь	Дүн	Хувь	
1	2021 оныг баталгаажуулсны дараах үлдсэн өртөг нөхөлтийн дүн, 2022 онд тооцох хувь	Гэрээлэгч	125,357,631.07	99.339	130,600,784.96	99.361	5,243,153.89
		МУЗГ	834,299.81	0.661	839,817.84	0.639	5,518.03
		Нийт	126,191,930.88	100.0	131,440,602.80	100.0	5,248,671.92
2	2022 оныг баталгаажуулсны дараах үлдсэн өртөг нөхөлтийн дүн, 2023 онд тооцох хувь	Гэрээлэгч	130,951,257.40	99.383	133,156,336.53	99.388	2,205,079.13
		МУЗГ	813,470.10	0.617	819,874.30	0.612	6,404.20
		Нийт	131,764,727.50	100.0	133,976,210.83	100.0	2,211,483.33

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Гэрээлэгч болон МУЗГ-ын хөрөнгө оруулалтын тухайн жилийн үлдэгдлийг нийт хөрөнгө оруулалтын үлдэгдэл дүнтэй харьцуулан тооцож, дараа жилд ногдох өртөг нөхөлтийн хувийг тооцоолно. Аудитаар 2022-2023 онуудын өртөг нөхөлтийн дүн, хувийг тооцоолж, АМГТГ-ын тооцоололтой зэрэгцүүлээ.

Хүснэгт 14. БХГ-97 талбайн МУЗГ-ын Хөрөнгө оруулалтын тооцоолол

/ам.доллар/

№	Үзүүлэлт	АМГТГ	Аудит	Зөрүү /Аудит-АМГТГ/
1	МУЗГ-ын анх оруулсан хөрөнгө оруулалт	5,037,619.00	5,037,619.00	-
2	Анх оруулсан хөрөнгө оруулалтыг 2003-2022 онуудад нөхсөн байдал	2003-2021	4,203,518.73	4,197,801.16
		2022	20,630.17	19,943.54
3	Нийт нөхсөн хөрөнгө оруулалт	4,224,148.90	4,217,744.70	(6,404.20)
4	Үлдсэн хөрөнгө оруулалт буюу ирээдүйд тосоор нөхөгдөх дүн	813,470.10	819,874.30	6,404.20

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Өмнөх аудитын тайлангаар 2003-2021 онд МУЗГ-ын нийт нөхсөн хөрөнгө оруулалтыг 4,197,801.16 ам.доллараар баталгаажуулсан. 2022 онд 19,943.54 ам.доллар нэмэгдэж, нийт 4,217,744.70 ам.долларын хөрөнгө оруулалтыг түүхий тосоор нөхсөн байна. Аудитаар 2022 оны жилийн эцсийн байдлаар МУЗГ-ын нийт өртөг нөхөгдөх зардлын үлдэгдэл буюу ирээдүйд тосоор нөхөх хөрөнгө оруулалтыг 819,874.30 ам.доллараар баталгаажууллаа.

²⁶ Гэрээлэгч нь хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардал, төлбөр урамшуулал, нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт тосны хуваарилалт, борлуулалт, орлого, зардлын бүртгэл, тооцоо зэрэг холбогдох тайлан мэдээг төрийн захиргааны байгууллагад зохих журмын дагуу гаргаж өгнө.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

АМГТГ-ын хяналт шалгалт болон аудитаар хасаж тооцсон борлуулалтын зардлын тооцооллоос шалтгаалан МУЗГ-ын үлдсэн хөрөнгө оруулалт буюу ирээдүйд тосоор нөхөгдөх дүн 6,404.20 ам.доллараар зөрүүтэй байна.

Хүснэгт 15. БХГ-97 талбайн ӨНЗ-ын үлдэгдлийн тооцоолол

/ам.доллар/

№	Он	Аудит				АМГТГ	Зөрүү /Аудит- АМГТГ/
		Хөрөнгө оруулалт	Өртөгт тосоор нөхөгдсөн зардал	Тухайн онд үлдсэн нөхөгдөх зардал	Үлдсэн хөрөнгө оруулалт буюу ирээдүйд тосоор нөхөгдөх дүн	Үлдсэн хөрөнгө оруулалт буюу ирээдүйд тосоор нөхөгдөх дүн	
А	Б	В /Хүснэгт 5/	Г /Хүснэгт 6/	Д /В-Г/	Е	Ё	Ж
1	2021	-	-	-	130,600,784.96	125,357,631.07	5,243,153.89
2	2022	5,656,662.22	3,101,110.65	2,555,551.57	133,156,336.53	130,951,257.40	2,205,079.13
Нийт дүн		5,656,662.22	3,101,110.65	-	-	-	-

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Аудитаар 2022 оны жилийн эцсийн байдлаар гэрээлэгчийн нийт өртөг нөхөгдөх зардлын үлдэгдэл буюу ирээдүйд тосоор нөхөх хөрөнгө оруулалтыг нийт борлуулалтын орлогын тооцооллын зөрүүгээс шалтгаалан АМГТГ-ын баталгаажуулалтаас 2,205,079.13 ам.доллараар зөрүүтэй буюу 133,156,336.53 ам.доллараар баталгаажууллаа.

1.1.2.3. АУДИТААР ЭКСПОРТОЛСОН ГАЗРЫН ТОСНЫ ХЭМЖЭЭГ 96,981.09 БАРРЕЛЬ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫГ 7,802,635.47 АМ.ДОЛЛАРООР БАТАЛГААЖУУЛЛАА.

Экспортолсон газрын тос:

Гэрээлэгчийн БХГ-97 талбайгаас 2022 онд Амбер ХХК-ийн хэмжиж баталгаажуулснаар 13 удаагийн 241 вагонцистерн ачилтаар 95,764.56 баррель газрын тос экспортолсон.

Хүснэгт 16. БХГ-97 талбайн 2022 онд экспортолсон газрын тос

/баррель/

Гэрээлэгч/АМГТГ протоколд						Аудит					
ачилт		буулгалт		зөрүү		ачилт		буулгалт		Зөрүү	
тоо	брл	тоо	брл	буцаж ирсэн	хорогдол	тоо	брл	тоо	брл	буцаж ирсэн	хорогдол
241	95,764.56	271	96,981.09	(94.03)	(1,216.53)	241	95,764.56	271	96,981.09	(94.03)	(1,216.53)

Эх сурвалж: Гэрээлэгч болон АМГТГ-ын БХГ-97 талбайгаас 2022 онд олборлосон хий, тос, усны тооцоог баталгаажуулсан 2023.03.10-ны өдрийн протокол

Гэрээлэгч, АМГТГ-ын баталгаажуулсан протоколын 2 дугаар хавсралтаар экспортолсон тосны ачилт буулгалтыг баталгаажуулсан байна. Мэдээнд ачилт буулгалтын вагонцистерн 30 нэгжээр зөрүүтэй байгаа нь хятад вагоны хэмжээ бага учир шилжүүлэн ачихад вагоны тоо нэмэгддэг, хятад вагонууд тосны үлдэгдэлтэй ирдэг учир 94.03 баррель тосны илүүдэлтэй. Экспортын ачилт буулгалтын зөрүү 1,216.53 баррель тосыг орлогын тооцоонд оруулсан байна.

Борлуулалтын зардал:

Гэрээлэгч нь БХГ-ний 2 дугаар зүйлийн 2.1²⁷, 8 дугаар зүйлийн 8.4.в²⁸ хэсгийг баримтлан борлуулалтын зардлыг тээвэр, шилжүүлэлт, үйл ажиллагаа /цалин, цахилгаан, туслах материал/-ны зардал гэж ангилан бүртгэж тайлагнасан.

²⁷ ...Экспортын цэг гэж гэрээт тос буюу хийн олборлолтын хэмжилт хийх цооногийн амны төхөөрөмж, эсвэл бусад байгууламж дээрх буюу тэдгээрийн ойролцоох цэгийг хэлнэ;

²⁸ Экспортын үнэ гэж бараагаар солилцох, дотоод зах зээл дээр борлуулах буюу бусад тусгай нөхцөл бүхий хэлбэрийг үл оролцуулан, өөрийн харьяа бус байгууллагаас экспортын цэг дээр буюу түүний ойролцоо газар чөлөөт валютаар худалдан авсан цэвэр үнийг хэлнэ. Экспортын үнийг тогтоохдоо экспортын цэгээс гэрээт түүхий тосыг нийлүүлэх тодорхой цэг хүртэлх өртөг зардлыг хасаж тооцно.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хүснэгт 17. БХГ-97 талбайн 2022 оны борлуулалтын зардал

/ам.доллар/

№	Үзүүлэлт	БХГ-97		Зөрүү
		Гэрээлэгч	АМГТГ	Гэрээлэгч-АМГТГ
1	Тээврийн зардал	45,780.00	45,780.00	-
2	Шилжүүлэлтийн зардал	950,286.99	404,374.01	545,912.98
3	Үйл ажиллагааны зардал:	582,059.72	39,479.60	542,580.12
3.1	Цалингийн зардал	394,168.15	-	394,168.15
3.2	Цахилгааны зардал	74,308.65	7,012.99	67,295.66
3.3	Туслах материалын зардал	113,582.92	32,466.61	81,116.31
	Дүн	1,578,126.71	489,633.61	1,088,493.10

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Гэрээлэгч нь 2022 оны борлуулалтын зардалд 2,165,482.40 ам.долларыг тайлагнасан ч бүтээгдэхүүн хуваах тооцооны мэдээнд цар тахлын улмаас борлуулалт хийгдээгүй 1, 2 дугаар улирлын 587,355.69 ам.долларыг хасаж, 3, 4 дүгээр улирлын 1,578,126.71 ам.долларын зардлыг тайлагнасан байна.

АМГТГ-ын хяналтаар гэрээлэгчийн тайлагнасан борлуулалтын зардлаас 1,088,493.10 ам.долларыг хасаж, 489,633.62 ам.доллар гэж дүгнэсэн байна. АМГТГ нь дээрх хассан зардлаас 637,621.20 ам.долларыг өртөг нөхөгдөх зардалд шилжүүлэн тооцож, мөнгөөр төлөгдөөгүй, ажлын төлөвлөгөө төсвийн дагуу зарцуулаагүй, бэлэг дурсгалын зардал зэрэг нийт 450,871.89 ам.долларыг хасаж дүгнэсэн.

Хүснэгт 18. БХГ-97 талбайн 2022 оны борлуулалтын зардлын тооцоо

/ам.доллар/

Үзүүлэлт	Гэрээлэгчийн тайлагнасан борлуулалтын зардал	Шалгалтаар хасагдуулсан тооцоо			Борлуулалтын зардалд тооцох дүн
		ГТБТЖ 3.1.3, 3.1.7, 3.1.28 заалтаар хассан	ӨНЗ-д залруулсан	Дүн	
Тээврийн зардал	45,780.00	-	-	-	45,780.00
Шилжүүлэлтийн зардал	950,286.99	450,871.89	95,041.09	545,912.98	404,374.01
Үйл ажиллагааны зардал:	582,059.72	-	-	542,580.11	39,479.61
Цалингийн зардал	394,168.15	-	394,168.15	394,168.15	-
Цахилгааны зардал	74,308.65	-	67,295.65	67,295.65	7,013.00
Туслах материалын зардал	113,582.92	-	81,116.31	81,116.31	32,466.61
АМГТГ-ын дүгнэлтээр	1,578,126.71	450,871.89	637,621.20	1,088,493.09	489,633.62
Аудит	1,578,126.71	450,871.89	637,621.20	1,088,493.09	489,633.62
Зөрүү	-	-	-	-	-

Аудитаар гэрээлэгчийн тайлагнасан борлуулалтын зардлыг ангиллын дагуу тухайн онд мөнгөөр төлөгдсөн, борлуулалт хийгдсэн 2022 оны 7-12 дугаар саруудын хугацааны үйл ажиллагаанд хамаарах зардлуудыг дахин тооцоолж, АМГТГ-ын хянасан зардалтай зэрэгцүүлэхэд 60,638.98 ам.долларын нэмэх зөрүүтэй буюу материаллаг хэмжээний зөрүүгүй тул АМГТГ-ын хянасан зардал 489,633.62 ам.доллороор баталгаажуулсан.

АМГТГ болон гэрээлэгч экспортын цэгийг харилцан тохиоогүй, Улсын Дээд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, мөн АМГТГ нь гэрээлэгчийн анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлээр Зүүнбаян танкфармын үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагааны өртөг зардлыг хуваарилан тодорхойлсон заавар аргачлалтай болох шаардлагатай байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Борлуулсан газрын тос:

Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.14²⁹-т заасны дагуу газрын тосны экспорт, борлуулалтын орлогыг улирал бүрээр тайлагнаж, олборлолтын өдөр тутмын мэдээг цахим хэлбэрээр төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн байна.

Гэрээлэгч 2022 онд нийт 386,100.0 баррель түүхий газрын тос борлуулах төлөвлөгөө батлуулснаас 96,981.05 баррель түүхий газрын тос борлуулсан нь 25.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 19. БХГ-97 талбайн 2022 оны Борлуулсан газрын тос

/баррель/

Борлуулах тосны төлөвлөгөө	Борлуулалтын тайланд				АМГТГ	Аудит
	Худалдан авагчийн хүлээн авсан	Өмнөх оноос шилжиж ирсэн	Дараа онд шилжсэн	Борлуулсан тос		
386,100.0	96,981.05	-	-	96,981.05	96,981.05	96,981.05

Эх сурвалж: Гэрээлэгч болон АМГТГ-ын БХГ-97 талбайгаас 2022 онд олборлосон хий, тос, усны тооцоог баталгаажуулсан 2023.03.10-ны өдрийн протокол, АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Аудитаар экспортын буулгалтын мэдээний бүртгэлээрх газрын тосыг нэгтгэж, протоколын 2 дугаар хавсралт болон гэрээлэгчийн борлуулалтын тайлангаарх борлуулсан тосны хэмжээтэй тулгаж шалгахад зөрүүгүй байна.

Газрын тосны борлуулалтын орлого:

Гэрээлэгч БХГ-97 талбайгаас олборлосон түүхий тосыг худалдах, худалдан авах гэрээг БНХАУ-ын Эрээн хотын Гаоули олон улсын эдийн засаг, худалдааны компанитай 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр DS/GL-LHY/01-2022 гэрээг байгуулжээ. Гэрээнд 2022 оны 5, 7 дугаар саруудад нэмэлт өөрчлөлт оруулж, 2022 оны 10 дугаар сард худалдан авагчтай гэрээг шинэчлэн байгуулсан байна.

Хүснэгт 20. Борлуулалтын гэрээний үнийн өөрчлөлт

/ам.доллар/

Гэрээний огноо	Гэрээний дугаар	Гэрээний төрөл	Хамаарах он	Үнийн тохируулга	
				Тохируулга	Тохируулсан үнэ
2022.01.14	DS/GL-LHY/01-2022	Үндсэн гэрээ	2022.02.01-2023.01.31		7.60
2022.05.30	DS/GL-LHY/01-2022	Нэмэлт гэрээ	2022.05.30-2022.06.30	3.00	10.60
2022.07.05	DS/GL-LHY/01-2022	Нэмэлт гэрээ	2022.07.01-2022.10.26	(1.00)	9.60
2022.10.27	DS/GL-HK/01-2022	Үндсэн гэрээ	2022.10.27-2022.12.10	4.21	13.81

Тус гэрээний 6.1-т 2022 оны 5 болон 7 сард 2 удаа өөрчлөлт оруулан энэхүү гэрээний хугацаанд газрын тосны худалдан авах үнэ нь тухайн сарын туршид Платс сэтгүүлд хэвлэгдсэн DMD brent газрын тосны дундаж баррель тутамд 2022 оны 5-6 дугаар сард 10.60 ам.доллар, 7-10 дугаар сарын 26-ны өдөр хүртэл 9.60 ам.доллар, 10 дугаар сарын 27-ны өдрөөс 13.81 ам.долларыг тээвэр, борлуулалтын зардалд тооцон хасахаар, нэмэлт ерөнхий нөхцөлийн хэсэг 6.2-т заасан үнийн шаардлагатай тохируулгыг хийсэнтэй тэнцүү байна гэсэн байна.

Гэрээлэгч нь өмнөх хугацаанд АМГТГ-тай харилцан зөвшилцөхгүй борлуулалтын үнэ тогтоож байсан тул АМГТГ-ын даргын 2022 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн А/85 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг БХГ-97 талбайгаас олборлон экспортолж буй газрын тосны үнийг хэлэлцэн тогтоосон байна.

²⁹ санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тос хуваах тооцоог энэ хуулийн 7.1.4-т заасан журмын дагуу үнэн зөв гаргаж, төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Гэрээлэгчийн 2015 онд байгуулсан тос борлуулах гэрээнд DMD brent газрын тосны баррель тутамд 5.20 ам.доллар хасаж тооцох заалтыг мөрдөж ажиллах саналыг гэрээлэгчид хүргүүлсэн байна.

Хүснэгт 21. БХГ-97 талбайн 2022 оны борлуулалтын орлого

/ам.доллар/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 он			Зөрүү	
	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч-АМГТГ	АМГТГ-Аудит
Борлуулсан тосны хэмжээ /брл/	96,981.05	96,981.05	96,981.05	-	-
Борлуулсан тосны орлого /ам.доллар/	8,292,269.08	8,292,269.08	8,292,269.08	-	-
Борлуулалт, тээврийн зардал	1,578,126.72	489,633.61	489,633.61	1,088,493.11	-
1 брл тосны борлуулалт, тээврийн зардал /дундаж/	16.27	5.05	5.05	11.22	-
Цэвэр борлуулалт	6,714,142.36	7,802,635.47	7,802,635.47	(1,088,493.11)	-

Эх сурвалж: АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Гэрээлэгч нь 2022 онд 96,981.05 баррель түүхий тос борлуулсны 8,292,269.08 ам.долларын орлогоос 1,578,126.72 ам.долларын борлуулалтын зардлыг хасаж, нийт борлуулалт 6,714,142.36 ам.долларыг тайлагнасан байна.

АМГТГ-ын шалгалтаар гэрээлэгчийн тайлагнасан борлуулалтын зардлаас 1,088,493.11 ам.долларыг хасаж тооцон борлуулалтын орлогыг 7,802,635.47 ам.доллаароор хянаж, дүгнэснийг аудит хэвээр баталгаажуулав.

1.1.2.4. АМГТГ НЬ БХГ-97 ТАЛБАЙН 2022 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ТООЦООГ ХЯНАЖ, МУЗГ-Т НОГДОХ ОРЛОГЫГ ГЭРЭЭЛЭГЧИЙН ТООЦООЛЛООС 303.0 МЯНГАН АМ.ДОЛЛАР ИЛҮҮ БУЮУ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХЭЭР ДҮГНЭСЭН БАЙНА.

МУЗГ-т төлөх роялти:

Гэрээлэгч 2022 оны нийт борлуулалт 6,714,142.36 ам.долларыг тайлагнаж, МУЗГ-т нөөц ашигласны төлбөрт 503,560.68 ам.доллар ногдуулан төлөхөөр тооцсон байна.

Хүснэгт 22. БХГ-97 талбайн МУЗГ-т төлөх роялти

/ам.доллар/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 он			Зөрүү	
	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч-АМГТГ	АМГТГ-Аудит
Борлуулсан тосны хэмжээ /брл/	96,981.05	96,981.05	96,981.05	-	-
Борлуулсан тосны орлого /ам.доллар/	8,292,269.08	8,292,269.08	8,292,269.08	-	-
Борлуулалт, тээврийн зардал	1,578,126.72	489,633.61	489,633.61	1,088,493.11	-
Нийт борлуулалт	6,714,142.36	7,802,635.47	7,802,635.47	(1,088,493.11)	-
РОЯЛТИ	503,560.68	585,197.66	585,197.66	(81,636.98)	-

АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

АМГТГ-ын шалгалтаар гэрээлэгчийн 2022 оны нийт борлуулалтыг 7,802,635.47 ам.доллар, үүнээс МУЗГ-т нөөц ашигласны төлбөрт 585,197.66 ам.доллар ногдуулан дүгнэсэн нь гэрээлэгчийн тооцооллоос 81,636.98 ам.долларыг нэмэгдүүлэн нөхөн төлүүлэхээр тооцсон байна.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Бүтээгдэхүүн хуваалт:

Газрын тосны тухай хуулийн 33.2³⁰, БХГ-ний 8 дугаар зүйлийн 8.3 дугаар заалтуудыг үндэслэн Монгол Улсын Засгийн газарт ноогдох ашигт газрын тосыг хоногт олборлох газрын тосны хэмжээтэй уялдуулан хуваана. Гэрээлэгч БХГ-97 талбайгаас 2022 онд 3,524,924.74 ам.долларын ашигт тосыг тооцоолж, МУЗГ-т 503,560.68 ам.долларын газрын тосны нөөц ашигласны төлбөр, 20,679.56 ам.долларын өртөгт газрын тос, 1,365,908.34 ам.долларын ашигт газрын тос нийт 1,890,148.57 ам.долларын орлого ногдох тайлан ирүүлсэн.

Хүснэгт 23. БХГ-97 талбайн 2022 оны Бүтээгдэхүүн хуваах тооцоо

№	Утга	Мөр дугаар	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Зөрүү	
						Гэрээлэгч-АМГТГ	АМГТГ-Аудит
1	Экспортолсон тос (баррель)	А	96,981.05	96,981.05	96,981.05	-	-
2	Борлуулсан тосны үнэ	Б	8,292,269.08	8,292,269.08	8,292,269.08	-	-
3	1 баррель газрын тосны борлуулалт, тээврийн зардал	В	15.66	5.44	5.44	10.22	-
4	Борлуулалт, тээврийн зардал	Г	1,578,126.72	489,633.61	489,633.61	1,088,493.11	-
5	"БХГ-97"-ний 8.4 в-ийн дагуу тооцсон дүн буюу цэвэр борлуулалт	Д /Б-Г/	6,714,142.36	7,802,635.47	7,802,635.47	(1,088,493.11)	-
6	Роялти	Е /Д*7.5%/	503,560.68	585,197.66	585,197.66	(81,636.98)	-
7	Үлдэх тос	Ё /Д-Е/	6,210,581.68	7,217,437.81	7,217,437.81	(6,122.77)	-
8	Өртөгт газрын тос	Ж /Д*40%/	2,685,656.94	3,121,054.19	3,121,054.19	(435,397.24)	-
	МУЗГ-т ногдох	З	20,679.56	20,630.17	19,943.54	49.39	686.63
	Гэрээлэгчид ногдох	И	2,664,977.39	3,100,424.02	3,101,110.65	(435,446.63)	(686.63)
	Ашигт газрын тос	Й /Д-Е-Ж/	3,524,924.74	4,096,383.62	4,096,383.62	(571,458.88)	-
9	МУЗГ-38.75%	К	1,365,908.34	1,587,348.65	1,587,348.65	(221,440.32)	-
	Гэрээлэгч-61.25%	Л	2,159,016.40	2,509,034.97	2,509,034.97	(350,018.57)	-
	МУЗГ-т ноогдох дүн	М	1,890,148.57	2,193,176.48	2,192,489.85	(303,027.91)	686.63
10	Роялти	Н	503,560.68	585,197.66	585,197.66	(81,636.98)	-
	Ашигт газрын тос	О	1,365,908.34	1,587,348.65	1,587,348.65	(221,440.32)	-
	Өртөгт газрын тос	Ө	20,679.56	20,630.17	19,943.54	49.39	686.63
11	Гэрээлэгчид ноогдох дүн	П	4,823,993.79	5,609,458.99	5,610,145.62	(785,465.20)	(686.63)
	Өртөгт газрын тос	Р	2,664,977.39	3,100,424.02	3,101,110.65	(435,446.63)	(686.63)
	Ашигт газрын тос	С	2,159,016.40	2,509,034.97	2,509,034.97	(350,018.57)	-

АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

АМГТГ-ын шалгалтаар МУЗГ-т ногдох нийт орлогыг 2,193,176.48 ам.доллараар дүгнэсэн, аудитаар 2,192,489.85 ам.доллараар тооцоолсон нь 686.63 ам.долларын зөрүү нь материаллаг бус тул МУЗГ-т ногдох тосны орлогыг АМГТГ-ын тооцоолсон 2,193,176.48 ам.доллараар баталгаажуулж, гэрээлэгчээс 303,027.91 ам.долларын орлогыг нөхөн төвлөрүүлэхээр баталгаажууллаа.

Гэрээлэгч нь Улсын Дээд шүүхийн тогтоолоор шийдвэрлэгдсэн 2014-2018 оны баталгаажуулах аудитаар өгсөн 4,094,004.96 ам.долларын улсын төсөвт төвлөрүүлэх албан шаардлага, 2019-2021 оны баталгаажуулах аудитаар тогтоосон 981,929.53 ам.долларын төлбөрийн актыг тус тус барагдуулаагүй зөрчлийг давтан гаргасаар байгаад Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг тодорхой арга хэмжээ авч ажиллахгүй байна.

1.2. АМГТГ НЬ ГЭРЭЭЛЭГЧИЙН ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БХГ-НИЙ ДАГУУ ТӨЛӨХ ТӨЛБӨР ХУРААМЖ, УРАМШУУЛЛЫН ТООЦООГ ДҮГНЭЭГҮЙ, ТООЦОО НИЙЛЖ БАТАЛГААЖУУЛААГҮЙ БАЙНА.

³⁰ Ашигт газрын тосны Засгийн газарт ногдох хэмжээг хоногт олборлох газрын тосны хэмжээтэй уялдуулан бүтээгдэхүүн хуваах гэрээнд тодорхойлон заана.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

1.2.1. АМГТГ НЬ ГЭРЭЭЛЭГЧИЙН 2022 ОНЫ БХГ-97 ТАЛБАЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ТООЦООНООС ҮҮССЭН ОРЛОГЫГ ХЯНАСАН Ч, ТӨСӨВТ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ЭСЭХИЙГ ДҮГНЭЭГҮЙ БАЙНА.

Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1³¹, БХГ-ний 8 дугаар зүйлийн 8.1.а³², Газрын тосны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2³³, МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан ГТБТЖ-ын 5 дугаар зүйлийн 5.4.1³⁴ дэх заалтыг тус тус хэрэгжүүлнэ.

Хүснэгт 24. БХГ-97 талбайн 2022 оны МУЗГ-т төвлөрүүлэх тосны орлогын тооцоо

/ам.доллар/

№	Үзүүлэлт	Гэрээлэгчийн тайлагнасан	АМГТГ-ын хяналт, шалгалтаар	Аудитаар	Зөрүү	
					Гэрээлэгч-АМГТГ	АМГТГ-Аудит
1	Хуваах тос/цэвэр борлуулалт	6,714,142.36	7,802,635.47	7,802,635.47	(1,088,493.11)	-
2	МУЗГ-т ногдох Үүнээс: Гэрээлэгчид ногдох	1,890,148.57	2,193,176.48	2,192,489.85	(303,027.91)	686.63
3		4,823,993.79	5,609,458.99	5,610,145.62	(785,465.20)	(686.63)
4	Тосны орлого төвлөрүүлэлт	1,908,536.90	1,908,536.90	1,908,536.90	-	-
Зөрүү		18,388.33	(284,639.58)	(283,952.95)	303,027.91	(686.63)

АМГТГ-ын 2024.12.09-ний өдрийн 1/5145 албан тоотгоор ирүүлсэн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн газрын тосны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт тайлан

Гэрээлэгч БХГ-97 талбайн 2022 оны бүтээгдэхүүн хуваах тооцооллоор МУЗГ-т ногдох тосны тооцоог 1,890,148.57 ам.доллар ногдуулахаар тайлагнасан.

АМГТГ-ын Төрийн сан банкны 100900000752 дансанд 932,782.52 ам.долларыг 2022 онд, 975,754.38 ам.долларыг 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрөөс 3 дугаар сарын 29-ний өдрүүдэд хугацаа хоцроосон, дутуу төвлөрүүлсэн 284,639.53 ам.долларыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, дүгнээгүй байна.

Аудитаар гэрээлэгчийн борлуулсан газрын тосны цэвэр борлуулалтын орлогын зөрүүгээс үүссэн 81,636.98 ам.доллар, бүтээгдэхүүн хуваах тооцооллын зөрүүгээс ашигт газрын тосны МУЗГ-т төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлсэн 203,002.60 ам.доллар, нийт 284,639.58 ам.долларыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

1.2.2. АМГТГ НЬ ГЭРЭЭЛЭГЧТЭЙ ЖИЛ БҮР ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ТӨЛБӨР, ХУРААМЖ, УРАМШУУЛЛЫН ТООЦООГ ДҮГНЭЭГҮЙ, ҮЛДЭГДЛИЙГ БАТАЛГААЖУУЛААГҮЙ БАЙНА.

Тайлант онд Газрын тосны тухай хуулийн 34 дүгээр зүйл, БХГ-ний 10 дугаар зүйл зүйлд заасан урамшуулал, үйлчилгээний хөлс, бусад төлбөр 141,975.00 ам.долларыг төвлөрүүлэхээс 119,724.87 ам.долларыг төвлөрүүлж, орон нутгийг хөгжүүлэх урамшуулал 29,711.44 ам.долларын төлбөрийг хугацаа хоцроон төлсөн байна.

Хүснэгт 25. БХГ-97 талбайн 2022 оны МУЗГ-т төвлөрүүлэх төлбөр, хураамжийн орлого

/ам.доллар/

№	Үзүүлэлт	Төвлөрүүлэх орлого	Хяналт		Зөрүү /Төлөвлөгөө-Аудит/	Хугацаа	
			АМГТГ	Аудит		Төвлөрүүлэх	Төвлөрүүлсэн
1	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	11,975.00	11,975.00	11,975.00	-	Санхүүгийн жил эхэлснээс 30 хоногийн дотор	2022.01.25

³¹ Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 хувь байна;

³² Гэрээлэгч хуанлийн улирал бүрд борлуулсан гэрээт тосны үнийн хэмжээний 7.5 хувьтай тэнцэх хэмжээний роялтийг төлнө;

³³ Ашигт газрын тосны МУЗГ-т ногдох хэмжээг хоногт олборлох газрын тосны хэмжээтэй уялдуулан БХГ-д тодорхойлон заана;

³⁴ Нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тосны тооцоог олборлож худалдсан хуанлийн сар бүр хийх.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

2	Сургалтын урамшуулал	60,000.00	60,000.00	60,000.00	-		2022.01.25
3	Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг	30,000.00	30,000.00	30,000.00	-		2022.01.25
4	Орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	40,000.00	10,288.56	10,288.56	29,711.44		2022.10.25
5	2022 нөхөн сэргээх баталгаа барьцаа	-	-	11.97		Жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор	2022.10.12
				7,449.34			2022.10.12
Нийт дүн		141,975.00	112,263.56	119,724.87	29,711.44		

АМГТГ нь гэрээлэгчийн тайлант онд төсөвт төвлөрүүлэх орлого, үлдэгдлийн дүнг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, дүгнэлт тайланд орон нутгийг хөгжүүлэх урамшуулал 29,711.44 ам.долларын дутуу төлбөрийг төлсөн эсэхийг дүгнээгүй нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9³⁵ дэх хэсэгт заасантай нийцээгүй байна.

Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.33³⁶, 11 дүгээр зүйлийн 11.2.9³⁷-т заасны дагуу гэрээлэгч 2022 оны 10 дугаар сард Төрийн сангийн эсхрөу дансанд 7,461.31 ам.доллар байршуулсан байна. ГТБТЖ-ын 8 дугаар зүйлийн 8.5³⁸-д заасны дагуу гэрээлэгч цар тахлын улмаас 2022 оны II хагас жилээс эхлэн борлуулалт хийж эхэлсэн тул мөнгөн хөрөнгө нэмж байршуулаагүй байна.

1.2.3. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТОДОРХОЙ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАЖ БАЙГАА БОЛОВЧ ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТЫН БИЕЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Өмнөх аудитаар дараах 2 төлбөрийн актыг тогтоож, 7 зөвлөмжийг хүргүүлснээс зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг АМГТГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/487 тоот бичгээр, биелэлтийг АҮЭБЯ-аас 2025 оны 08 дугаар сарын 08-ний өдрийн 02/2255 тоот бичгээр, 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1/4924 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Хүснэгт 26. Аудитын шийдвэрийн хэрэгжилт

№	Төлбөрийн актын дугаар	Төлбөрийн актын огноо	Дүн /ам.доллар/	Төвлөрүүлэх хугацаа	Тайлбар
1	193/A0160057СНАГ-2024/02-НА-НА	2024.12.30	1,049.33	2025.05.15	Барагдуулаагүй
2	194/A0160057СНАГ-2024/02-НА-НА	2024.12.30	980,880.20	2025.12.15	Барагдуулаагүй

№	Зөвлөмжийн товч утга	Хэрэгжүүлж буй арга хэмжээ	Биелэлт
Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад:			

³⁵ Газрын тосны борлуулалтын орлогоос ЗГ-т ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34-р зүйлд заасан төлбөр урамшууллыг хугацаанд нь төсөв төвлөрүүлэх;

³⁶ "ашигт газрын тос" гэж хүргэлтийн цэг дээр хэмжсэн нийт газрын тосноос энэ хуулийн 4.1.26, 4.1.32-т заасан газрын тосыг хасаад Засгийн газар болон гэрээлэгчийн хооронд хуваах газрын тосыг;

³⁷ байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эсхрөу дансанд байршуулах;

³⁸ энэ журмын 8.3-т заасан төсвийн дагуу тооцож, эсхрөу дансанд байршуулсан баталгаа нь тухайн жилийн гүйцэтгэлээр баталгааны дүнгээс дутуу бол нэмж байршуулах, илүү бол дараа жил байршуулах баталгаанд шилжүүлэн тооцно.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

1	АМГТГ хяналт шалгалтыг хэрхэн хийх, дүгнэх, тайлагнах талаар мөрдөх заавар, аргачлал батлах;	Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, дүгнэх, тайлагнах талаар мөрдөх заавар аргачлалын төсөл боловсруулах АҮЭБС-ын 2025 оны А/18, Газрын тосны салбарын хууль эрх зүйн орчныг шинэчлэх, ЗГ болон яамдаас санал авах, хэлэлцүүлэх А/144 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгүүд ажиллаж байна.	Хэрэгжих шатандаа
2	Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Улсын Дээд шүүхийн гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;	Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой АҮЭБС-ны ТНБД-ын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 02/490 тоот албан бичгээр АМГТГ-т чиглэл хүргүүлсэн байна.	Хэрэгжих шатандаа
АМГТГ-ын даргад:			
3	АМГТГ хяналт шалгалтыг хэрхэн хийх, дүгнэх, тайлагнах талаар мөрдөх заавар, аргачлал боловсруулж, батлуулах, хяналтын үйл явцыг программчлах арга хэмжээ авах;	АҮЭБС-ын 2025 оны А/144, А/194, А/195 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд “Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах”, “Газрын тосны бүртгэл тооцооны журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль, журмын төслийг боловсруулан ажиллаж байна. Мөн Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-тай хамтран ӨНЗ-ын хяналтын цахим системийг нэвтрүүлэхээр хүсэлтээ хүргүүлсэн байна.	Хэрэгжих шатандаа
4	Гэрээлэгчдэд хийж буй хяналт шалгалтыг газрын даргын тушаалаар Ажлын хэсэг байгуулах бус хариуцсан газар, хэлтсийн үндсэн үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтээр хэрэгжилтийг хангах;	Газрын тосны ашиглалтын хэлтсийн үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тооцоонд хяналт, шалгалт хийх, дүгнэлт гаргах” арга хэмжээг тусгасан байна.	Хэрэгжсэн
5	Гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, газрын тосны экспорт, борлуулалтын орлого зөрүүтэй байвал хянан шалгаж, зөрүүтэй асуудлыг дүгнэлт тайланд бүрэн тусгаж ирүүлж байх;	БХГ-97 талбайн 2023 оны өртөг нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын зөрүүг тооцон хяналт шалгалтын дүгнэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 3/4532 дугаар албан бичгээр “Доншен газрын тос Монгол” ХХК-д хүргүүлсэн байна.	Хэрэгжих шатандаа
6	Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн газрын тос олборлох технологид ашиглагдаж буй усны заалт болон төлбөрийн нэхэмжлэхийг цооног, худгийн байршлаар нь ангилж нэгтгэж нийт ашигласан усны тооцоог гаргаж, оролцогч талуудын жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулж акт үйлдэх, тус аудитаарх акт болон гэрээлэгчийн АМГТГ-тай хийсэн протоколын дүнгийн зөрүүг тодорхойлж, арга хэмжээ авч ажиллах;	Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн газрын тосны олборлох технологид ашиглагдаж буй усны заалт болон төлбөрийн нэхэмжлэхийг цооног, худгийн байршлаар нь ангилж, нийт ашигласан усны тооцоог гаргаж, 2024 оноос эхлэн тооцоо нийлж, тосны протоколоор баталгаажуулсан байна.	Хэрэгжих шатандаа
7	Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг хэрэгжүүлж, шийдвэрийн биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэх	АМГТГ-аас зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, явцын биелэлтийг ТАБ-д ирүүлсэн. Төлбөрийн актыг барагдуулах тухай албан бичгийг 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/690 тоот бичгээр гэрээлэгчид хүргүүлсэн боловч гэрээлэгч төлж барагдуулаагүй байна.	Хэрэгжих шатандаа



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Улсын дээд шүүхийн 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 001/ХТ2023/0015 дугаар тогтоолын “Хянавал” хэсгийн 13-т “Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д “Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно.” гэж заасан бөгөөд төрийн өмчид хамаарах байгалийн баялаг болох газрын тосыг зүй зохистой ашиглах бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газраас эрх олгосноор, хуульд заасан чиг үүргийн дагуу төрийн захиргааны байгууллагаас хуулийн этгээдтэй байгуулсан дээрх “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” нь захиргааны гэрээнд хамаарна” гэж тодорхойлсон.

Тус захиргааны гэрээ буюу БХГ нь Захиргааны ерөнхий хуульд нийцсэн байх ба тус хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-т “Захиргааны гэрээний агуулгын голлох ач холбогдол бүхий харилцаа тухайн гэрээг байгуулснаас хойш бүхэлдээ өөрчлөгдсөн, гэрээний аль нэг тал гэрээний анхны зохицуулалтыг цаашид баримтлах боломжгүй гэж үзсэн бол уг гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй”, 56.2-т “Өөрчлөх боломжгүй, эсхүл гэрээний аль нэг тал өөрчлөлт оруулахгүй гэж үзвэл захиргааны гэрээг цуцална” гэж заасны дагуу МУЗГ болон төрийн захиргааны байгууллага гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардах, экспортын цэгтэй холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэх боломжтой байна.

Иймд өмнөх оны аудитаар тогтоосон 5,075,934.49 ам.доллар буюу 11,435,537,062.08 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Улсын Дээд шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож, арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

БҮЛЭГ 2. АМГТГ НЬ ПЕТРОМАТАД ХХК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГЫГ ХЯНАЖ ХҮЛЭЭЖ АВСАН Ч ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАЛААРХ НОТЛОХ БАРИМТЫН БҮРДЭЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

2.1. АМГТГ НЬ ГЭРЭЭЛЭГЧИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХАЙГУУЛ ҮНЭЛГЭЭНИЙ ХӨРӨНГИЙГ 2,939,136,957.51 ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭН ТАЙЛАГНАСНЫГ ГАЗРЫН ТОСНЫ БҮРТГЭЛ, ТООЦООНЫ ЖУРАМД НИЙЦҮҮЛЖ, ДҮГНЭЭГҮЙ БАЙНА

2.1.1. АМГТГ хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрүүлж, маргаантай асуудлыг шийдвэрлэсэн дүгнэлт, тайлан ирүүлээгүйгээс баталгаажуулах аудитыг гүйцэтгэхэд хүндрэл учирч, аудитын шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна

“Матад ХХ” талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар АМГТГ болон “Петроматад инвест лимитед”-ийн хооронд шинэчлэн байгуулсан БХГ-ний 15 дугаар зүйлийн 15.2.1³⁹, мөн гэрээний Г Хавсралтаар төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх тайлангийн төрөл, хугацааг нарийвчлан зохицуулсан байна.

Хүснэгт 1. Матад ХХ талбайн үйл ажиллагааны тайлан, мэдээ

№	Үзүүлэлт	Гэрээлэгчийн тайлан ирүүлсэн хугацаа	АМГТГ-ын хүлээн авсан хугацаа	Тайлбар
1.7.1	БХГ-ний Г Хавсралтын 1.7.1. Хуанлийн сар бүр дууссанаас хойш 30 хоногийн дотор			
1.7.1.1.	Газрын тосны олборлолт, ашиглалт, борлуулалтын мэдээ, тайлан	-	-	Олборлолт хийгдээгүй тул газрын тосны олборлолт, ашиглалт,

³⁹ Гэрээлэгч эсхүл оператор компани нь санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан болон нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тосны хуваалтын тооцооны тайланг зохих журмын дагуу төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

1.7.1.2.	Нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тосны тооцоо, тайлан	-	-	борлуулалтын мэдээ, тайлан ирүүлээгүй
1.7.2	БХГ-ний Г Хавсралтын 1.7.2. Хуанлийн улирал бүр дууссанаас хойш 30 хоногийн дотор, тайлант жил дууссанаас хойш 60 хоногийн дотор			
1.7.2.1.	Санхүүгийн тайлан, тодруулга	2023.02.28	2023.02.28	I улирлын тайлан 2022.04.29
1.7.2.2.	Үндсэн хөрөнгө, бараа материалын орлого, зарлага, үлдэгдлийн дэлгэрэнгүй тайлан /тухайн Үндсэн хөрөнгө, бараа материал нь ӨНЗ-д тооцогдсон эсэхийг тэмдэглэнэ/	2023.02.28	2023.02.28	II улирлын тайлан 2022.07.29
				III улирлын тайлан 2022.10.28
1.7.2.3.	Өртөг нөхөгдөх зардлын тайлан	2023.02.28	2023.02.28	Жилийн эцсийн тайланг 2023.02.28-нд тус тус
1.7.2.4.	Захиргааны зардлын тайлан	2023.02.28	2023.02.28	хүргүүлсэн байна.

Гэрээлэгч төрийн захиргааны байгууллагад БХГ-ний Г Хавсралтын 1.7.1-д “Хуанлийн сар бүр дууссанаас хойш 30 хоногийн дотор Газрын тосны олборлолт, ашиглалт, борлуулалтын мэдээ, тайлан, Нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тосны тооцоо, тайлан хүргүүлнэ” гэж заасан боловч олборлолт хийгдээгүй тул газрын тосны олборлолт, ашиглалт, борлуулалтын мэдээ, тайлан ирүүлээгүй байна.

Харин БХГ-ний Г хавсралтын 1.7.2⁴⁰-т заасны дагуу АМГТГ нь гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын хураангуй болон дэлгэрэнгүй тайлан, захиргааны зардлын тайланг хугацаанд нь хүлээн авсан хэдий ч хяналт шалгалт хийсэн талаарх нотлох баримтын бүрдэл хангалтгүй байсан тул гэрээлэгчийн санхүүгийн анхан шатны баримтыг татаж тулгаж үзэв.

Мөн гэрээлэгчээс 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 070/024 тоот бичгээр АМГТГ-ын хяналт шалгалтын дүгнэлт, тайлангийн төсөлд 44,336.26 ам.долларын зардлыг хасахыг зөвшөөрөхгүй гэсэн саналыг ирүүлснийг шалтгаан нөхцөлийг тодруулж, эцэслэн шийдвэрлээгүй байна.

Цаашид хяналт шалгалт хийсэн өртөг нөхөгдөх зардлын тайлангийн санхүүгийн анхан шатны баримтыг иж бүрэн хангалтай нотлох баримтын шаардлагад нийцүүлж бүрдүүлэх, хяналт шалгалтын дүнг гэрээлэгчид танилцуулж, өртөг нөхөгдөх зардлаас хасагдах зардал болон хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрүүлж, аливаа маргаан зөрчлийг эцэслэн шийдвэрлэсэн дүгнэлтийг ТАБ-д ирүүлж байхаар ГТБТЖ-д нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

2.1.2. АМГТГ НЬ ГЭРЭЭЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГЫГ ХЯНАЖ ХҮЛЭЭЖ АВСАН Ч ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАЛААРХ НОТЛОХ БАРИМТЫН БҮРДЭЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

АМГТГ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8⁴¹, БХГ-ний 15 дугаар зүйлийн 15.3.1⁴²-т заасныг хэрэгжүүлж ажиллана.

АМГТГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг БХГ-ний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулах эрх бүхий Петроматад ХХК-ийн Матад ХХ гэрээт талбайд 2022, 2023 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайланд анхан шатны баримтад үндэслэн хяналт шалгалт хийж, ТАБ-д дүгнэлт тайланг 2024 оны 1/2566 дугаар, 2025 оны 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Мөн МУЕА-ын 2024 оны А/117 дугаар тушаалаар баталгаажуулсан “Газрын тосны салбарт БХГ-ээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө

⁴⁰ Хуанлийн улирал бүр дууссанаас хойш 30 (гуч) хоногийн дотор, тайлант жил дууссанаас хойш 60 (жар) хоногийн дотор.

⁴¹ Гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж нэгтгэх;

⁴² гэрээний 15.2-т заасан тайлан мэдээг Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнаж байгаа байдалд төрийн захиргааны байгууллага байнгын хяналт тавьж ажиллана.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт"-д хийсэн ТАБ-ын нийцлийн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн дагуу АМГТГ нь Матад ХХ талбайн 2021 оны 7-12 сарын хугацааны ашиглалтын үйл ажиллагааг дахин шалгаж, дүгнэлт тайланг ТАБ-д 2025 оны 1/494 дүгээр албан бичгээр ирүүлснийг тайланд нэмж, өмнөх аудитад тусгагдсан гэрээлэгчийн төлөвлөгөө, төсөв, гүйцэтгэлд орсон өөрчлөлтийг залруулж тайлагналаа.

Аудитаар АМГТГ нь гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны өртөг нөхөгдөх зардлын тайлангийн анхан шатны баримт материалыг үндэслэн дүгнэсэн эсэхийг тулгаж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Матад ХХ талбайн 2021.07-2023 оны ашиглалтын үйл ажиллагааны тайлан хянасан байдал

№	Үзүүлэлт	Анхан шатны баримтад үндэслэсэн эсэх	Бүрэн хянаж дүгнэсэн	Дүгнэлтийг хянасан талаар
1	Батлагдсан төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл	Тийм	Бүрэн	Гэрээлэгч нийт 7,081.5 мянган ам.долларын төсөв батлуулсан. Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийг тоо хэмжээгээр ажил тус бүрээр гарган төсөвтэй зэрэгцүүлэн хянаж дүгнэсэн
2	Хөрөнгө оруулалт	Тийм	Бүрэн	Гэрээлэгчийн нийт зардлын гүйцэтгэлийг 4,850.2 мянган ам.доллароор тооцон дүгнэсэн
3	Өртөг нөхөгдөх зардал	Тийм	Бүрэн	Гэрээлэгчийн ӨНЗ-ыг 1,974.1 мянган ам.доллароор тооцон дүгнэсэн. Эхний хяналтын дараах ТАБ-ын зөвлөмжийн дагуу 2021 оны 7-12 сарын ашиглалтын үйл ажиллагааны дүгнэлтийг салган гаргаж, ТАБ-д ирүүлсэн
4	Үйл ажиллагааны зардал	Тийм	Бүрэн	Гэрээлэгчийн Монгол Улс дахь оффисын зардлыг ГТБТЖ-ын 2.2.8-г баримтлан 50 хувиар тооцсон. Хувийг 2010 оны 2 талын протоколоор хэлэлцэж, тогтоосон
5	Газрын тосны олборлолт, экспорт, борлуулалт, бүтээгдэхүүн хуваалт	Тийм	Бүрэн	2021 оны 7-р сард олборлолтын үйл ажиллагаанд шилжсэн ч 2021.07-2023 онд олборлолт, борлуулалт, бүтээгдэхүүн хуваах үйл ажиллагаа гараагүй талаар дүгнэсэн байна
6	Санхүүгийн тайлан, ӨНЗ-ын тайлангийн уялдаа	Тийм	Бүрэн	Хайгуул үнэлгээний хөрөнгийг Газрын тосны хөрөнгөд шилжүүлэн тайлагнах талаар албан бичгээр хүргүүлсэн тухай дурдсан байна
7		Үгүй	Дутуу	2022 онд хайгуул үнэлгээний хөрөнгийг 2,939,136,957.51 төгрөг, 2023 онд Газрын тосны хөрөнгийг 2,889,863,766.87 төгрөгөөр нэмэгдүүлэн тайлагнасныг дүгнээгүй байна

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланг шалгаж, ТАБ-д 2024.06.11-ний өдрийн 1/2566, 2025.01.29-ний өдрийн 1/494, 2025.05.02-ны өдрийн 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт тайлан

Гэрээлэгч УУХҮС-ын /хуучнаар/ 2021 оны А/36 дугаар тушаалаар Цэн тогоруу ордын газрын тосны нөөцийн баталгаат зэрэглэл 1.15 сая.тн, ашиглалтын баталгаат нөөц 137.9 мянган.тн-оор ашигт малтмалын нөөцийн санд бүртгэж авч, УУХҮС-ын 2021 оны А/186 дугаар тушаалаар 696 дугаартай газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл олгосон байхад 2022 оны санхүүгийн тайланд Хайгуул үнэлгээний хөрөнгийг газрын тосны хөрөнгөнд шилжүүлэн тайлагнаагүй нь МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ГТБТЖ-ын 9 дүгээр 9.3.16⁴³-д заасантай нийцэхгүй байна.

⁴³ Хайгуулын ажлын үр дүнд үр ашигтай нээлт тогтоогдож, ордыг ашиглах талаар гэрээлэгч эсхүл оператор компани шийдвэр гаргасан үед Хайгуул үнэлгээний хөрөнгийг Газрын тосны хөрөнгөнд шилжүүлэн бүртгэнэ;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Мөн 2022 оны санхүүгийн тайланд хайгуул үнэлгээний хөрөнгийг 2,939,136,957.51 төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэсэн нь МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ГТБТЖ-ын 9 дүгээр зүйлийн 9.4.6⁴⁴; 9.4.9⁴⁵-т заасантай тус тус нийцээгүй байна.

Энэ талаар АМГТГ дүгнэлтдээ “газрын тосны ашиглалтын үйл ажиллагааг санхүүгийн тайланд тайлагнасан зардлыг хянахад ГТБТЖ-ын 9 дүгээр зүйлийн 9.3.13-т “хайгуулын ажлын үр дүнд үр ашигтай нээлт тогтоогдож, ордыг ашиглах талаар гэрээлэгч, эсхүл оператор компани шийдвэр гаргасан үед хайгуул, үнэлгээний хөрөнгийг газрын тосны хөрөнгөд шилжүүлэн бүртгэнэ” гэж заасны дагуу шилжүүлж бүртгэх, 9.4-т заасан ашиглалтын үеийн зардлыг журамд заасны дагуу санхүүгийн тайланд тайлагнах талаар гэрээлэгчид 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 3/2329 дугаар албан бичгээр хүргүүлсэн” гэж дурджээ.

Аудитаар МУЗГ-ын 178-р тогтоолоор баталсан журамд заасны дагуу 2022 оны Санхүүгийн тайланд Хайгуул үнэлгээний хуримтлагдсан хөрөнгийг баталгаажсан нөөцийн тоо хэмжээнд үндэслэн газрын тосны хөрөнгөд шилжүүлэн бүртгэх, олборлолтын үйл ажиллагааны зардлуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар залруулж тайлагнах зөвлөмж өглөө.

Мөн гэрээлэгч 2023 оны санхүүгийн тайланд Газрын тосны хөрөнгийг 2,889,863,766.87 төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэсэн нь ГТБТЖ-ын 9 дүгээр зүйлийн 9.4.2⁴⁶, 9.4.9⁴⁷-т заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд ГТБТЖ-ын дагуу зардлыг хөрөнгийн шинж чанартай бол үндсэн хөрөнгө, тайлант үеийн зардлаар /алдагдал/ ангилан бүртгэх зөвлөмжийг өглөө.

Хүснэгт 3. Санхүүгийн тайланд тусгагдсан дүн

/мян.төг/

Он	Балансын зүйл	Санхүүгийн тайлан /Гэрээлэгч/			Аудитаар залруулсан үлдэгдэл	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Залруулах дүн		
2022	Хайгуул үнэлгээний хөрөнгө	53,956,899.66	56,896,036.62	2,939,136.96	53,956,899.66	Газрын тосны хөрөнгөд шилжүүлэх
2023	Газрын тосны хөрөнгө	56,889,333.00	59,779,197.00	2,889,864.00	53,956,899.66	Зардлыг залруулах

Гэрээлэгч 2021.07-2023 онд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй тул БХГ-ний Хавсралт Г.1.7.1-д заасан тайлангуудыг /Хүснэгт 1-ээр үзүүлсэн/ гаргаагүй, 2022 оны Г.1.7.2-д заасан тайлангуудыг хугацаанд нь бүрэн ирүүлж, АМГТГ нь 2021 оны тайланг хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг салгаж тайлагнаагүй байсныг өмнөх аудитын зөвлөмжөөр тусад нь тайлагнаж ирүүлсэн болно.

АМГТГ нь гэрээлэгчийн 2022-2023 оны бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хийгээгүй нь МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ГТБТЖ-ын 4 дүгээр зүйлийн 4.3.1⁴⁸-т заасантай нийцээгүй байна.

АМГТГ нь гэрээлэгчийн 2021.07-2023 оны мэдээ тайлангуудыг хугацаанд нь хянаагүй, хугацааны хоцрогдолтой 1-2 жилийн дараа хянаж байгаа нь завсар дундын


⁴⁴ Газрын тос, уламжлалт бус газрын тосыг олборлох, цуглуулах, дамжуулах, цэвэршүүлэх, хадгалах, тээвэрлэх болон борлуулах хүртэлх ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн туслан гүйцэтгэгч нарт төлсөн төлбөр, ашиглалтын тусгай зөвшөөрлийн хорогдлын зардал, олборлох үйл ажиллагаатай холбоотой хуримтлуулсан зардлын тайлант үеийн элэгдлийн зардал, гэрээлэгч, эсхүл оператор компанийн олборлолтын ажилтай шууд хамааралтай ажилчдын цалин хөлс, тэтгэмж, ашигласан бараа материал, шатахуун зэрэг хайгуулын үйл ажиллагаатай холбоотой нийтлэг зардлуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд тайлант үеийн зардлаар бүртгэнэ;

⁴⁵ Олборлолтын үйл ажиллагааны зардлуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар тайлагнана.

⁴⁶ Бүтээн байгуулалттай холбоотой хөрөнгийн шинжтэй зардлуудыг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын үндсэн хөрөнгийн дагуу бүртгэлд тусгана. Бүтээн байгуулалтын үед хийгдэж буй дэд бүтцийн зардлуудыг бий болгож буй биет хөрөнгийг ангиллын дагуу дуусаагүй барилга дансанд хөрөнгийн ангиллын дагуу туслах дансанд бүртгэнэ;

⁴⁷ Олборлолтын үйл ажиллагааны зардлуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар тайлагнана;

⁴⁸ ГТАЭТЗБ нь гэрээлэгч, эсхүл оператор компанийн үйл ажиллагааны эд материал, биет хөрөнгө, барилга байгууламжийн тооллогыг хийнэ;



Иймд АМГТГ-т БХГ-ний заалтын дагуу гэрээлэгчийн тайлан, мэдээнүүдийг хүлээн авсан талаар бүртгэлжүүлж, тухайн тайлан мэдээнүүдийг тухайн цаг хугацаанд нь шалгаж, алдаа зөрчлийг тухай бүр залруулсны дараа дараагийн тайланг хүлээн авдаг системтэй болох, ГТБТЖ-д нэмж тусгах шаардлагатай байна.

Гэрээлэгч нь 2021-2023 онд гүйцэтгэх жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3⁴⁹, 11.2.3⁵⁰, БХГ-ний 9 дүгээр зүйлийн 9.2-т нийцүүлэн АМГТГ-т хүргүүлснийг АМГТГ нь 2021 оны 7-12 сард гүйцэтгэх жилийн ажлын төлөвлөгөөний төсвийг 1,073,647.0 ам.доллар, 2022 оны төсвийг 2,957,244.0 ам.доллар, 2023 оны төсвийг 3,050,610.7 ам.доллар, нийт 7,081,501.68 ам.доллараар баталсан байна.

/ам.доллар/

⁴⁹ Шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны байгууллагын зөвшөөрснөөр жилийн төлөвлөгөө, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

2	Олборлолтын зардлын дүн	552,081.43	552,081.43	-	-	552,081.43
3	Аюулгүй ажиллагаа болон байгаль орчны хамгаалах ажил	81,889.00	81,889.00	-	-	81,889.00
4	Үйл ажиллагааны зардал	1,582,656.76	1,582,656.76	-	-	1,582,656.76
5	Захиргааны зардлын дүн	104,427.74	104,427.74	-	-	104,427.74
	Дүн	2,918,685.68	2,918,685.68	-	-	2,918,685.68
6	Өртөг нөхөгдөхгүй зардал	131,925.00	131,925.00	-	-	131,925.00
	Нийт дүн	3,050,610.68	3,050,610.68	-	-	3,050,610.68
	НИЙТ ТӨСВИЙН ДҮН					7,081,501.68

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланг шалгаж, ТАБ-д 2024.06.11-ний өдрийн 1/2566, 2025.01.29-ний өдрийн 1/494, 2025.05.02-ны өдрийн 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт тайлан

Гэрээлэгч 2021-2023 оны өртөг нөхөгдөх зардлын тайлангаарх гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний төсвийн гүйцэтгэл 2,298,675.17 ам.доллар буюу 33.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт 5. Матад XX талбайн 2021.7-2023 онд хийх ажлын төлөвлөгөөний төсвийн гүйцэтгэл

/ам.доллар/

№	Ажлын хөтөлбөр	Төсөв /2021.07-2023/	Гүйцэтгэл 2021.07-2023 он			Гүйцэтгэлийн зөрүү /+хасах, - нэмэх/	
			Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч АМГТГ	АМГТГ-Аудит
1	Бүтээн байгуулалтын зардал	1,089,071.75	75,792.54	67,529.17	67,529.17	8,263.37	-
2	Олборлолтын зардлын дүн	2,045,120.43	292,897.55	165,297.40	173,484.09	127,600.15	(8,186.69)
3	Аюулгүй ажиллагаа болон байгаль орчны хамгаалах ажил	230,108.00	35,131.96	21,496.84	21,496.84	13,635.12	-
4	Үйл ажиллагааны зардал	3,169,842.76	1,783,591.04	1,645,195.74	1,643,095.49	138,395.30	2,100.25
5	Захиргааны зардлын дүн	255,306.74	111,262.08	98,705.65	99,009.97	12,556.43	(304.32)
	Дүн	6,789,449.68	2,298,675.17	1,998,224.80	2,004,615.57	300,450.37	(6,390.77)
6	Өмнөх оны төлөвлөгөө, төсөв дэх ажилд зарцуулсан дүн	-	74,593.75	74,593.75	74,593.75	-	-
7	Өртөг нөхөгдөхгүй зардал	292,052.00	2,476,933.74	2,777,384.11	2,770,993.35	(300,450.37)	6,390.76
	Нийт дүн	7,081,501.68	4,850,202.66	4,850,202.66	4,850,202.66	-	-

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланг шалгаж, ТАБ-д 2024.06.11-ний өдрийн 1/2566, 2025.01.29-ний өдрийн 1/494, 2025.05.02-ны өдрийн 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт тайлан

АМГТГ нь өртөг нөхөгдөх зардлын тайланд анхан шатны баримтад үндэслэн хяналт хийж, гэрээлэгчийн 2021-2023 онд гүйцэтгэх жилийн ажлын төлөвлөгөөний төсвийн



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

гүйцэтгэлээс 287,893.93 ам.долларын зардлыг хасаж, 1,998,224.80 ам.доллар буюу 29.4 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Аудитаар гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын тайлан, АМГТГ-ын хянаж дүгнэсэн ӨНЗ-ын дүнг анхдагч баримт материал, нотлох баримтад үндэслэн аудит хийж гэрээлэгчийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг 2,004,615.57 ам.доллар буюу 29.5 хувьтай байна. Төсвийн гүйцэтгэлийг өртөг нөхөгдөх зардлаас хассан зардал 281,807.48 ам.доллараар хасаж тооцоолсон.

БХГ-ний 12 дугаар зүйлийн 12.2.6⁵¹-д заасны дагуу гэрээлэгч нь тухайн жилийн нийт хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй тооцоолол, тайланг гаргаж ирүүлснийг АМГТГ хянаж, дүгнэхээр зохицуулсан байдаг.

Хүснэгт 6. Матад ХХ талбайн 2021.07-2023 оны нийт зардлын дүн

/ам.доллар/

Хөрөнгө оруулалт- өртөг нөхөгдөх зардал	Зэрэгцүүлэлт			Зөрүү	
	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч- АМГТГ	АМГТГ- Аудит
Өртөг нөхөгдөх зардал /тайлангаар/	2,262,006.84	2,262,006.84	2,262,006.84	-	-
Хяналт, шалгалтаар хасагдсан дүн	-	287,893.93	281,807.48	(287,893.93)	6,086.45
ӨНЗ-ын дүн	2,262,006.84	1,974,112.91	1,980,199.36	287,893.93	(6,086.45)
Захиргааны зардал 5%	111,262.08	98,705.64	99,009.96	12,556.44	(304.32)
Дүн	2,373,268.92	2,072,818.55	2,079,209.33	300,450.37	(6,390.77)
Өртөг нөхөгдөхгүй зардал	2,476,933.74	2,777,384.11	2,770,993.34	(300,450.37)	6,390.77
Нийт дүн	4,850,202.66	4,850,202.66	4,850,202.66	-	-

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланг шалгаж, ТАБ-д 2024.06.11-ний өдрийн 1/2566, 2025.01.29-ний өдрийн 1/494, 2025.05.02-ны өдрийн 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт тайлан

Гэрээлэгч 2021 оны 7 дугаар сараас 2023 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний төсвийн гүйцэтгэл нь өртөг нөхөгдөх зардлын тайланд 2,373,268.92 ам.доллар, өртөг нөхөгдөхгүй зардалд 2,476,933.74 ам.доллар, нийт 4,850,202.66 ам.долларыг зарцуулсан гэж тайлагнасан.

АМГТГ-ын шалгалтаар нийт өртөг нөхөгдөх зардлын төсвийн гүйцэтгэл 2,072,818.55 ам.доллар, өртөг нөхөгдөхгүй зардалд 2,777,384.11 ам.долларыг зарцуулж, нийт 4,850,202.66 ам.доллар гэж дүгнэсэн байна. Шалгалтаар өртөг нөхөгдөх зардлаас 287,893.93 ам.долларыг хасаж өртөг нөхөгдөхгүй зардлаар дүгнэсэн.

Аудитаар АМГТГ-ын хянасан дүгнэлтээр өртөг нөхөгдөх зардлын төсвийн гүйцэтгэлээс хасагдсан 287,893.93 ам.долларын зардал дээр 6,086.45 ам.долларын зардлыг буцаан нэмж 2,079,209.33 ам.доллар, өртөг нөхөгдөхгүй зардал 2,770,993.34 ам.доллар, нийт 4,850,202.66 ам.доллараар баталгаажуулсан.

МАТАД ХХ ТАЛБАЙН ГАЗАР АШИГЛАХ ЭРХ ШИЙДЭГДЭЭГҮЙ ТУЛ 2021.07-2023 ОНД ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА

Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1⁵²-т заасныг 2021-2023 онд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлээгүй байна.

УУХҮС-ын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн А/186 дугаар тушаалаар 696 дугаартай газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл олгосон. УУХҮЯ-наас 2022 оны 7 дугаар

⁵¹ Гэрээлэгч нь хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардал, төлбөр урамшуулал, нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт тосны хуваарилалт, борлуулалт, орлого, зардлын бүртгэл, тооцоо зэрэг холбогдох тайлан мэдээг төрийн захиргааны байгууллагад зохих журмын дагуу гаргаж өгнө.

⁵² Аймгийн засаг дарга нь газрын тосны тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тэдгээрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, үр дүнг хариуцах, дэмжлэг үзүүлэх.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

сарын 8-ны өдөр БХБЯ-нд Матад ХХ талбайн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулах 218 км² талбайг тусгай хэрэгцээнд авч, газрын бүртгэлийн нэгдсэн санд бүртгүүлэх хүсэлт хүргүүлжээ.

ГЗБГЗЗЕГ-аас 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 1/1446 дугаар албан бичгээр Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, санал авах талаар Дорнод аймгийн Засаг даргад хүсэлт хүргүүлсэн байна. Өнгөрсөн хугацаанд Матад ХХ талбайг тусгай хэрэгцээнд авч, газар ашиглалтын төлөвлөгөөнд оруулахаар Матад сумын ИТХ-аар 2022 онд 9 удаа хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй байна.

ГЗБГЗЗЕГ-аас Матад ХХ ашиглалтын талбайг улсын хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулж, МУЗГ-ын 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 265 дугаар тогтоолоор баталсан байна.

Матад ХХ талбайн газар ашиглах эрхийн асуудал 2021.07-2023 онд шийдэгдээгүй тул гэрээлэгч газрын тосны олборлолт, экспорт, борлуулалтын үйл ажиллагаа явуулаагүй байна.

Иймд МУЗГ-аас баталсан БХГ болон УУХҮС-ын газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл олгосон байхад хууль тогтоомжийн дагуу холбогдох эрх олгохгүй, үйл ажиллагаанд саад учруулж буй орон нутгийн засаг захиргаанд тодорхой арга хэмжээ авах, энэ тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар журамлах шаардлагатай байна.

АУДИТААР МАТАД ХХ ТАЛБАЙН 2021.07-2023 ОНЫ ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫГ 1,980.2 МЯНГАН АМ.ДОЛЛАРООР БАТАЛГААЖУУЛЛАА

Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.31⁵³, 32 дугаар зүйлийн 32.1⁵⁴, 32.2⁵⁵, БХГ-ний 12 дугаар зүйлд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх өртөг, зардлыг гэрээлэгч хариуцаж, БХГ-д заасан өртөгт газрын тосны хувиар нөхөн авахаар зохицуулсан байна.

Гэрээлэгч өртөг нөхөгдөх зардлын тайланд 2021 оны 7-12 дугаар сард 362,182.39 ам.доллар, 2022 онд 1,070,350.96 ам.доллар, 2023 онд 829,473.49 нийт 2,262,006.84 ам.долларын зардал тайлагнасан байна.

Хүснэгт 7. Матад ХХ талбайн 2021.07-2023 оны өртөг нөхөгдөх зардал

/ам.доллар/

Он	ӨНЗ			Зөрүү	
	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч АМГТГ	АМГТГ Аудит
2021.07-2021.12	362,182.39	340,237.29	340,237.29	21,945.09	-
2022	1,070,350.96	949,136.41	955,148.83	121,214.55	(6,012.43)
2023	829,473.49	684,739.20	684,813.22	144,734.29	(74.02)
Дүн	2,262,006.84	1,974,112.90	1,980,199.34	287,893.93	(6,086.45)

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланг шалгаж, ТАБ-д 2024.06.11-ний өдрийн 1/2566, 2025.01.29-ний өдрийн 1/494, 2025.05.02-ны өдрийн 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт тайлан

АМГТГ-ын хяналтаар гэрээлэгчийн тайлагнасан 2,262,006.84 ам.долларын өртөг нөхөгдөх зардлын тайланг анхан шатны баримтад үндэслэн шалгаж, хууль тогтоомжид нийцээгүй 287,893.93 ам.долларын зардлыг хасаж тооцон 1,974,112.90 ам.долларын өртөг нөхөгдөх зардлыг тооцоолсон байна.

Аудитаар гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлын тайлангийн ажил гүйлгээ, зардлуудыг БХГ болон бусад хууль тогтоомжид нийцсэн эсэх, мөнгөөр төлөгдсөн эсэх, мөнгөн хөрөнгийн журналд бүрэн тайлагнасан эсэх, анхан шатны баримтын бүрдэл

⁵³ "өртөг нөхөгдөх зардал" гэж хайгуул, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, татан буулгалтын зардлын нийлбэрийг;

⁵⁴ Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зардлыг гэрээлэгч хариуцна;

⁵⁵ Өртөг нөхөгдөх зардлыг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулж, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан өртөгт газрын тосны хувиар нөхнө.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

хангасан эсэхийг шалгаж 281,807.50 ам.долларын зардлыг хассан нь АМГТГ-ын хянасан дүнгээс 6,086.45 ам.доллараар зөрүүтэй тооцоолсон.

Хүснэгт 8. Матад ХХ талбайн 2021.07-2023 оны
ӨНЗ-аас хассан зардал ангиллаар

/ам.доллар/				
№	Хасагдсан зардлын ангилал	АМГТГ	АУДИТ	Зөрүү /АМГТГ-Аудит/
1	Мөнгөөр төлөөгүй буюу өглөг	5,806.19	5,806.19	-
2	Цалингийн зардал	(10,501.34)	(10,501.34)	-
3	Захиргааны зардал	63,077.70	62,269.57	808.13
4	Анхан шатны баримтгүй	30,667.05	23,794.37	6,872.68
5	И-баримтгүй	31,869.21	31,868.31	0.90
6	Төлөвлөгөө, төсөвт тусгаагүй, хэтрүүлсэн, зөвшөөрөгдөөгүй	140,258.54	140,258.54	-
7	Ажлын тайланг АМГТГ-т ирүүлээгүй	9,500.00	9,500.00	-
8	Татвар, торгууль, төлбөр хураамж	13,683.31	13,683.31	-
9	Сургалт	3,528.40	3,528.40	-
10	Хандив, бэлэг	-	1,595.26	(1,595.26)
11	Хөнгөлөлт	4.97	4.97	-
ДҮН		287,894.03	281,807.58	6,086.45

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланг шалгаж, ТАБ-д 2024.06.11-ний өдрийн 1/2566, 2025.01.29-ний өдрийн 1/494, 2025.05.02-ны өдрийн 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт тайлан

АМГТГ-ын хяналтаар хасагдсан гэрээлэгчийн 2022 онд худалдан авсан зүүм камер дагалдах хэрэгслийн хамт 1,387.14 ам.доллар, тоног төхөөрөмжийн үнийг төгрөг, долларт шилжүүлэн, буруу ханшаар тооцоолсноос үүдэн хөрөнгийн дүнг дутуу тодорхойлсон 6,799.56 ам.доллар, шуудан болон цахилгааны төлбөр 74.02 ам.доллар, нийт 8,260.72 ам.доллараар нэмэгдүүлж, сургалтын зардал 1,595.26 ам.доллар, томилолтын зардал 20.74 ам.доллар, захиргааны үйлчилгээний зардал 558.34 ам.доллар, нийт 2,174.28 ам.долларыг хасаж, зөрүү 6,086.45 ам.доллараар гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлыг нэмэгдүүлэн залрууллаа.

Захиргааны үйл ажиллагааны зардалд 62,269.57 ам.долларын зардлыг давхардуулан тооцсон нь БХГ-ний Г хавсралт 2.3.11.2⁵⁶, 2.3.11.4⁵⁷-т заасантай тус тус нийцээгүй байна.

Мөн гэрээлэгч 2022 онд 595,883,255.46 төгрөг буюу 174,223.48 ам.доллар, 2023 онд 42,625,427.50 төгрөг буюу 12,229.94 ам.доллараар үндсэн хөрөнгө худалдан авч ӨНЗ-д тайлагнасан байна. /Үүнээс компьютер, түүний дагалдах хэрэгсэл 1,803.82 ам.доллар, программ хангамж 3,042.72 ам.долларын зардлыг ӨНЗ-аас хасаж тооцсон/

АМГТГ-ын зүгээс "орон нутгийн эсэргүүцлийн улмаас үйл ажиллагааг одоог хүртэл эхлүүлж чадаагүй, бүтээн байгуулалтын ажилд зориулан худалдан авсан тоног төхөөрөмжийг талбай дээр хүлээн авсан тул ашиглалтад тавьж олгосон гэж үзсэн" гэсэн тайлбар өгсөн ч дүгнэлт тайланд хэлэлцэн баталгаажуулсан шийдвэр хавсаргаагүй байна.

Энэ нь МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ГТБТЖ-ын 2 дугаар зүйлийн 2.2.2⁵⁸-т заасантай нийцээгүй байна.

Иймд гэрээлэгчийн буруутай биш үйл ажиллагаанаас шалтгаалж байгаа нөхцөлийг хэлэлцэн АМГТГ тухай бүрд нь шийдвэрлэж баталгаажуулж байх шаардлагатай байна.

Гэрээлэгч 2021.7-12 сар, 2022, 2023 онд өртөг нөхөгдөх зардалд 2,262,006.84 ам.долларын зардал тайлагнаж, компанийн захиргааны зардалд 111,262.08 ам.доллар

⁵⁶ Захиргааны зардал нь гэрээлэгч эсхүл оператор компанийн тухайн жилийн өртөг нөхөгдөх зардлын а.Эхний 1,000,000 ам.долларт-5.0 хувь ... тооцсон захиргааны зардлыг нэмж нийт өртөг нөхөгдөх зардалд тооцно;

⁵⁷ захиргааны зардлыг бусад (энэ хавсралтын 2.3.1-2.3.10 хүртэлх) зардалд давхардуулан тооцохгүй;

⁵⁸ Хайгуул, ашиглалт, татан буулгалтын үйл ажиллагаанд зориулан худалдан авсан тусгай зориулалтын машин, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, тоноглолын зардлыг ашиглалтад оруулсан үеэс өртөг нөхөгдөх зардалд тооцно.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

нэмэгдүүлэн тооцоолж, нийт 2,373,268.92 ам.долларын өртөг нөхөгдөх зардлыг тайлагнасан.

АМГТГ-ын шалгалтаар өртөг нөхөгдөх зардлаас 287,893.93 ам.долларыг хасаж, тооцооллын зөрүүгээс захиргааны зардлын 12,556.43 ам.долларыг хасаж, нийт өртөг нөхөгдөх зардлыг 2,072,818.56 ам.доллараар дүгнэсэн.

Хүснэгт 9. Матад ХХ талбайн 2021.7-2023 оны ӨНЗ-ын баталгаажуулалт

/ам.доллар/

Өртөг нөхөгдөх зардал	Тайлагнасан	Хянасан		Зөрүү/+, -/	
	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч АМГТГ	АМГТГ Аудит
Өртөг нөхөгдөх зардал /тайлангаар/	2,262,006.84	2,262,006.84	2,262,006.84	-	-
Хяналт шалгалтаар хасагдсан дүн	-	287,893.93	281,807.48	(287,893.93)	6,086.45
ӨНЗ-ын дүн	2,262,006.84	1,974,112.91	1,980,199.36	287,893.93	(6,086.45)
Захиргааны 5 хувь	111,262.08	98,705.65	99,009.97	12,556.43	(304.32)
Нийт дүн	2,373,268.92	2,072,818.56	2,079,209.34	300,450.36	(6,390.77)

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланг шалгаж, ТАБ-д 2024.06.11-ний өдрийн 1/2566, 2025.01.29-ний өдрийн 1/494, 2025.05.02-ны өдрийн 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт тайлан

Аудитаар АМГТГ-ын хяналтаар хасагдсан зардлыг хянаж, 6,086.45 ам.долларын зардлыг буцаан нэмж тооцсон. Захиргааны зардлыг тооцооллын зөрүүгээр 304.32 ам.доллараар нэмэгдүүлэн тооцоолж, нийт өртөг нөхөгдөх зардлыг 2,079,209.34 ам.доллараар баталгаажууллаа.

Хүснэгт 10. Матад ХХ талбайн нийт ӨНЗ-ын баталгаажуулалт

/ам.доллар/

№	Санхүүгийн жил	Баталгаажуулсан байгууллага	Баталгаажсан огноо	Өртөг нөхөгдөх зардал		Зөрүү
				Гэрээлэгчийн тайлангаар	Баталгаажсан	
1	2006	Сангийн яам, Уул уурхайн яам, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Газрын тосны газрын хамтарсан	2008.08.06	42,760.00	39,237.00	(3,523.00)
2	2007			1,166,794.00	1,132,970.00	(33,824.00)
3	2008		2009.12.29	3,423,613.13	3,283,834.90	(139,778.23)
4	2009		2010.12.29	1,891,025.38	1,702,312.50	(188,712.88)
5	2010		2012.11.26	8,687,272.18	8,085,206.91	(602,065.27)
6	2011		2015.01.06	23,457,253.00	23,340,897.91	(116,355.09)
7	2012			3,519,163.00	3,578,603.92	59,440.92
8	2013		2016.10.26	1,538,155.08	1,538,155.08	-
9	2014	Үндэсний аудитын газар	2016.11.09	502,873.32	502,872.32	(1.00)
10	2015		2018.03.31	142,726.00	142,726.00	-
11	2016			58,823.14	58,823.14	-
12	2017		2020.04.17	321,769.12	290,881.00	(30,888.12)
13	2018			300,142.05	299,269.30	(872.75)
14	2019		2023.02.08	13,170,302.10	11,985,820.40	(1,184,481.70)
15	2020		2023.12.19	471,695.27	-	(471,695.27)
16	2021 хайгуул			2025.12.30	850,725.87	296,630.38
17	2021.07.01 ашиглалт		357,249.16			
18	2022		1,122,461.49		1,002,906.28	(119,555.21)
19	2023		870,515.92		719,053.89	(151,462.04)
			Нийт дүн		61,538,070.05	58,357,450.09

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланг шалгаж, ТАБ-д 2024.06.11-ний өдрийн 1/2566, 2025.01.29-ний өдрийн 1/494, 2025.05.02-ны өдрийн 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт тайлан

АМГТГ-ын дүгнэлт тайланд гэрээлэгчийн 2023 оны жилийн эцэст өссөн дүнгээр өртөг нөхөгдөх зардал 57,992,237.44 ам.доллар, өртөг нөхөгдөхгүй зардал 11,894,354.38 ам.доллар, нийт хөрөнгө оруулалт 69,886,591.82 ам.доллар гэж дүгнэсэн байна.

АМГТГ-ын ирүүлсэн дээрх дүн нь 2024 оны 1/2566, 2025 оны 1/494, 2025 оны 1/2105 дугаартай албан бичигт гэрээлэгчийн 2006-2021 оны баталгаажсан нийт өртөг нөхөгдөх



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

зардлын дүнг алдаатай илэрхийлснийг аудитаар залруулж, гэрээлэгчийн 2023 оны эцсийн байдлаарх нийт өртөг нөхөгдөх зардлын үлдэгдлийг 58,357,450.09 ам.доллараар баталгаажууллаа.

Иймд дүгнэлт тайлангийн тоо дүнг нягталж, гэрээлэгчтэй тооцоо нийлж, эцэслэж ирүүлэх шаардлагатай байна.

2.2. АМГТГ НЬ ГЭРЭЭЛЭГЧИЙН ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БХГ-НИЙ ДАГУУ ТӨЛӨХ ТӨЛБӨР ХУРААМЖИЙГ ХЯНАСАН Ч БҮРЭН ДҮГНЭЭГҮЙ БАЙНА

2.2.1. АМГТГ НЬ ГЭРЭЭЛЭГЧТЭЙ ЖИЛ БҮР МУЗГ-Т ТӨЛӨХ ТӨЛБӨР, ХУРААМЖ, УРАМШУУЛЛЫН ТООЦООГ ХИЙЖ, ҮЛДЭГДЛИЙГ БАТАЛГААЖУУЛААГҮЙ БАЙНА

Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9⁵⁹, БХГ-ний 13 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 11. Матад ХХ талбайн 2021.07-2023 онд МУЗГ-т төвлөрүүлсэн орлого

/ам.доллар/

№	Үзүүлэлт	Төвлөрүүлэх орлого	Гүйцэтгэл			Хугацаа	
			АМГТГ	Аудит	Үлдэгдэл	Төвлөрүүлэх	Төвлөрүүлсэн
1	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	43,600.00	43,600.00	43,600.00	-	Санхүүгийн жил эхэлснээс 30 хоногийн дотор	Хугацаандаа
2	Сургалтын урамшуулал	60,000.00	60,000.00	60,000.00	-		14,876.71 ам.долларыг 2023.01.31-нд төлсөн
3	Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг	10,000.00	10,000.00	10,000.00	-		Хугацаа хоцроон төлсөн.
4	Орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	60,000.00	34,631.59	34,631.59	25,368.41		Орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулсан.
5	Экспроу дансны баталгаа	-	-	-	-	Өмнөх онд 12,000.00 ам.доллар байршуулсан	
Нийт дүн		173,600.00	148,231.59	148,231.59	25,368.41	-	-

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2021 оны 7-12 сар, 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тайланг шалгаж, ТАБ-д 2024.06.11-ний өдрийн 1/2566, 2025.01.29-ний өдрийн 1/494, 2025.05.02-ны өдрийн 1/2105 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт тайлан

Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эхлээгүй, олборлолт хийгээгүй тул газрын тосны экспорт, борлуулалт хийгээгүй тул хууль тогтоомжийн дагуу МУЗГ-т төлөх нөөцийн төлбөр, бүтээгдэхүүний хуваалтын тооцоо гараагүй байна.

Аудитаар гэрээлэгчийн нийт төсөвт төвлөрүүлэх орлогын дүнг мөнгөн хөрөнгийн харилцах дансны журналын гүйлгээтэй тулган шалгахад төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг 2,500.00 ам.долларыг 2022 оны 11 дүгээр сард, сургалтын төлбөрийн урамшуулал 14,876.71 ам.долларыг 2023 оны 01 дүгээр сард хугацаа хоцроон төлсөн байна.

Орон нутгийг хөгжүүлэх урамшуулал 2022 оны 5,088.00, 2023 оны 20,280.41 ам.доллар, нийт 25,368.41 үлдэгдлийг Матад сумын Засаг даргатай байгуулсан 2023 оны

⁵⁹ Газрын тосны борлуулалтын орлогоос ЗГ-т ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34-р зүйлд заасан төлбөр урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх;



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

12 дугаар сарын 24-ний өдрийн “Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх тухай” гэрээний дүнд багтаан 2024 оны 11 дүгээр сард төлсөн байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.17⁶⁰ дахь заалтын дагуу байгуулсан гэрээгээр БХГ-ний 13 дугаар зүйлийн 13.6.1⁶¹-т заасан гэрээлэгчийн үүргээс чөлөөлөх зохицуулалт байхгүй, мөн ГТБТЖ-ын 11 дүгээр зүйлийн 11.1⁶²-т заасантай нийцээгүй байна.

Иймд АМГТГ гэрээлэгчийн жил бүрийн төсөвт төвлөрүүлэх орлого, үлдэгдлийн дүнг тооцоо нийлж, баталгаажуулж, БХГ-ний хэрэгжилтийг хангах ажиллах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Цаашид БХГ-ээр хүлээсэн жил бүрийн төсөвт төвлөрүүлэх орлогыг хугацаанд нь төлөх, Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.17 дахь заалтын дагуу сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх арга хэмжээг ялгаж гэрээнд тусгах нь зүйтэй байна.

Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9⁶³-т заасны дагуу гэрээлэгч 2021 оны 6 дугаар сард Голомт банкны эскроу дансанд 12,000.00 ам.доллар байршуулсан байна. ГТБТЖ-ын 8 дугаар зүйлийн 8.5⁶⁴-д заасны дагуу гэрээлэгч 2022-2023 онд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй тул эскроу дансанд мөнгөн хөрөнгө нэмж байршуулаагүй байна.

2.2.2. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Өмнөх аудитаар АМГТГ-т 2020-2021 онуудад тусгай зөвшөөрлийн төлбөр, урамшуулал, үйлчилгээний дэмжлэг болох 3,254.00 ам.доллар, байгаль орчны баталгаа, төлбөр урамшуулал, үйлчилгээний дэмжлэг болох 15,123.00 ам.доллар буюу нийт 18,377.00 ам.долларын 1 төлбөрийн акт тогтоосныг Петроматад ХХК төлж барагдуулаагүй, 2019-2021 оны үйл ажиллагаанд хийсэн аудитаар өгсөн “Хайгуулын зардлыг хайгуул үнэлгээний хөрөнгө эсвэл хайгуулын зардал гэсэн 2 аргын аль нэгийг сонгож бүртгэхээр НБББББ-т тусгаж мөрдлөг болгох” 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 12. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

/ам.доллар/

7am:00/лар

Үзүүлэлт	Огноо	Аудитын шийдвэр						
		Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Биелээгүй		
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	хувь
Төлбөрийн акт	2020-2021	1	3,254.00	0	-	1	3,254.00	
			15,123.00		-		15,123.00	
Дүн		1	18,377.00	0	-	1	18,377.00	0%
Зөвлөмж	2021	3	-	2	-	1	-	
	2022	1	-	1	-	0	-	
Дүн		4	-	3	-	1	-	75%
Нийт дүн		5	18,377.00	3	-	1	18,377.00	60%

Дээрх гэрээлэгчийн аудитаар тогтоосон актын биелэлт 0 хувь, зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

⁶⁰ Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах;

⁶¹ БХГ-ний 13.6.1-т заасны дагуу гэрээлэгч эсхүл оператор компани нь орон нутгийг хөгжүүлэх урамшуулал 30,000 (гучин мянга)-н ам.долларыг үйл ажиллагаа явуулж буй сум орон нутгийг хөгжүүлэх санд жил бүр төлнө.

⁶² Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3, 9.1.8, 9.1.10, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, зарцуулсан зардал, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, төлбөр урамшууллын төлөлт, борлуулсан газрын тосны орлогын тооцоог үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавьж ажиллана;

⁶³ Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах;

⁶⁴ Энэ журмын 8.3-т заасан төсвийн дагуу тооцож, эскроу дансанд байршуулсан баталгаа нь тухайн жилийн гүйцэтгэлээр баталгааны дүнгээс дутуу бол нэмж байршуулах, илүү бол дараа жил байршуулах баталгаанд шилжүүлэн тооцно.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Холбогдох байгууллагын санал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Засгийн газрын XII байрны баруун жигүүр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуудан: info@mrpam.gov.mn,
Цахим хуудас: mrpam.gov.mn

2025.12.23 № 1/6503

танай _____-ны № _____-т

Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай

Танай 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 06/3513 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Петроматад" ХХК-ийн Матад ХХ талбайн 2021.07-2023 оны, "Доншен газрын тос (Монгол)" ХХК-ийн БХГ-97 талбайн 2022 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасны дагуу аудитын тайлангийн төсөлд өгөх санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 34 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

П.БАЯНБААТАР

1525414659



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Ашигт малтмал, газрын тосны газрын
2025 оны 14 дүгээр сарын 28-ний өдрийн
1/6528 тоот албан бичгийн хавсралт

Аудитын тайлангийн төсөлд өгөх тайлбар, санал

Нэг. “Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн 2021.07-2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн” аудитын тайлангийн төсөлд тусгагдсан зөвлөмжид өгөх тайлбар, санал:

Зөвлөмжийн 1-д

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/144, 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар “Газрын тосны бүртгэл, тооцооны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэгт АҮЭБЯ, АМГТГ-ын холбогдох албан тушаалтан болон газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгчдийн төлөөлөл, Газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлогчдын холбоо оролцон ажиллаж байгаа бөгөөд ажлын хэсгийн гишүүд журмын төсөлд саналаа өгч, нэгтгэн боловсруулж байна.

Зөвлөмжийн 2-д

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн А/186 дугаар тушаалаар Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн газрын тос ашиглах 696 дугаартай тусгай зөвшөөрөл олгогдсон боловч 2024 оны 05 дугаар сар хүртэл газар ашиглах эрхийн асуудалтай байсан тул ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлж чадаагүй.

Матад ХХ талбайн газрын тосны ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлэх хүрээнд газар ашиглах эрхийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Барилга, хот байгуулалтын яам руу Петроматад ХХК-ийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулах 218км² талбайг тусгай хэрэгцээнд авч, газрын бүртгэлийн нэгдсэн санд бүртгэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж өгөхийг хүссэн. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 1/1446 дугаар албан бичгээр Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, санал авах талаар Дорнод аймгийн засаг дарга М.Бадамсүрэнд хүргүүлсэн ба 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тухайн асуудлыг хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй. Мөн талбайг тусгай хэрэгцээнд авах, газар ашиглалтын төлөвлөгөөнд оруулах асуудлыг Матад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 2022 онд 9 удаа хэлэлцүүлж, үүнд Ашигт малтмал, газрын тосны газрын холбогдох ажилтнууд тухайн асуудлаар мэдээлэл, тайлбар өгч ажилласан боловч дэмжигдээгүй болно. Матад ХХ ашиглалтын талбайг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулж, тус талбайг Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 265 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан.

Петроматад ХХК-ийс 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 023/025 дугаар албан бичгээр ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаанд өөрчлөлт оруулах хүсэлтийг АМГТГ-т ирүүлсэн. Уг хүсэлтийн дагуу АМГТГ-ын Газрын тосны техникийн зөвлөл 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хуралдаж, саналаа Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 06



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

дугаар сарын 04-ний өдрийн А/145 дугаар тушаалаар "Петроматад" ХХК-ийн газрын тос ашиглах 974 дугаар тусгай зөвшөөрлийг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэхээр шинэчлэн тогтоож, 2049 оны 05 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаагаар олгосон.

Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн "Цэн тогоруу-1" цооногоос 2024 оны 10 дугаарын 25-ны өдрөөс эхлэн газрын тос олборлож эхэлсэн. "Түүхий тосыг итгэмжлэн шилжүүлэх, цэвэршүүлэх, худалдах гэрээний"-ний дагуу "Матад ХХ" талбайн "Цэн тогоруу-1" ордоос олборлосон түүхий тосоо "Тосон уул XIX" талбай дахь ТА-1 нэгдсэн байгууламжид тээвэрлэн хүргэж, анхан шатны боловсруулалт хийлгэн 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн экспортод гаргасан.

Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 9.3.16-д заасны дагуу Санхүүгийн тайланд "Хайгуул үнэлгээний хуримтлагдсан хөрөнгө"-ийг баталгаажсан нөөцийн тоо хэмжээнд үндэслэн газрын тосны хөрөнгөд шилжүүлэн бүртгэх, ашиглалтын үед гарсан зардлыг орлогын тайланд зардлаар залруулж тайлагнах талаар 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 3/2329 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

2024 оны Санхүүгийн тайландаа "Хайгуул үнэлгээний хуримтлагдсан хөрөнгө"-ийг баталгаажсан нөөцийн тоо хэмжээнд үндэслэн "Газрын тосны хөрөнгө"-д шилжүүлэн бүртгэн тайлагнасан. /Хавсралт 22 хуудас/.

Зөвлөмжийн 5-д

Засгийн газраас дэвшүүлсэн цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн инновац, шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, төрийн байгууллагын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид ил тод, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд газрын тосны хайгуул, ашиглалтын мэдээллийн системийг хөгжүүлэн ашиглахаар төлөвлөсөн бөгөөд цахим системтэй болсноор төлөвлөгөө, тайлан, мэдээг цахимаар хүлээн авах, хянах үйл ажиллагааг сайжруулах, шуурхай болгох, гаалийн болон татварын байгууллагуудтай цахим мэдээлэл солилцох, мэдээ тайланг холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх ажлын хүрээнд Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-тай газрын тосны хайгуул, ашиглалтын мэдээллийн систем хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх талаар уулзаж, санал солилцсон.

Газрын тосны хайгуул, ашиглалтын мэдээллийн системийг Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-аар гүйцэтгүүлэх шаардлагатай байгаа тухай 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1/3929 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүсэлтээ хүргүүлсэн.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хоёр. “Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайн 2022 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн” аудитын тайлангийн төсөлд тусгагдсан зөвлөмжид өгөх тайлбар, санал:

Зөвлөмж 1-д

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 17.1.7-д “...Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартыг хэрхэн мөрдөж байгаад харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналт тавих”, Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийг ашиглах журам”-ын 3.3-д “Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харьцдаг дараах аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайланг цахим хэлбэрээр болон батлагдсан маягтын дагуу биечлэн тушаах ба Сангийн яамны тухайн чиглэлийн асуудлыг хариуцаж буй газраар хянуулсны үндсэн дээр хүлээн авна.”, 3.3.2-т “Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан” гэж заасны дагуу тухайн чиглэлийн асуудлыг хариуцаж буй газарт хүргүүлж, хянуулсны үндсэн дээр хянаж, хүлээн авсан, цахимаар баталгаажсан санхүүгийн тайланг АМГТГ-т ирүүлдэг.

2011-2025 онуудад гэрээлэгч ашиглалтын үед гарсан зардлыг орлогын тайланд зардлаар тайлагнаж, хөрөнгийн шинжтэй зардлуудыг НББОУС-ын дагуу үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгадаг. Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбай 2011 онд ашиглалтад шилжих үедээ Санхүүгийн тайланд хуримтлагдсан “Хайгуул үнэлгээний хуримтлагдсан хөрөнгө”-ийг баталгаажсан нөөцийн тоо хэмжээнд үндэслэн “Газрын тосны хөрөнгө” дансанд шилжүүлэн бүртгэж тайлагнаагүй байсан. Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 9.4.7-д “ашиглалтын үеэс эхлэн газрын тосны хөрөнгө дансыг олборлосон бүтээгдэхүүний нэгжид үндэслэн хорогдуулан бүртгэнэ,” гэж заасны дагуу 2025 оны санхүүгийн тайланд залруулга хийх зөвлөмжийг хүргүүлж ажиллана.

Зөвлөмж 3-д

Засгийн газраас дэвшүүлсэн цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн инновац, шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, төрийн байгууллагын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид ил тод, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд газрын тосны хайгуул, ашиглалтын мэдээллийн системийг хөгжүүлэн ашиглахаар төлөвлөсөн бөгөөд цахим системтэй болсноор төлөвлөгөө, тайлан, мэдээг цахимаар хүлээн авах, хянах үйл ажиллагааг сайжруулах, шуурхай болгох, гаалийн болон татварын байгууллагуудтай цахим мэдээлэл солилцох, мэдээ тайланг холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх ажлын хүрээнд Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-тай газрын тосны хайгуул, ашиглалтын мэдээллийн систем хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх талаар уулзаж, санал солилцсон.

Газрын тосны хайгуул, ашиглалтын мэдээллийн системийг Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-аар гүйцэтгүүлэх шаардлагатай байгаа тухай 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1/3929 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүсэлтээ хүргүүлсэн.

Тайлангийн төсөлд дурдсан захиргааны зардлын хувь хэмжээний талаар:

Газрын тосны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д “бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, цуцлах эрхийг олгох, бүтээгдэхүүн хуваах гэрээгээр гэрээлэгчийн хүлээсэн эрх, үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх” гэж Засгийн газрын бүрийн эрхийг зааж өгсөн.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 78, 2023 оны 96, 199, 2024 оны 30, 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 62 дугаар захирамж, Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 51, 2023 оны 96 дугаар тушаал, УУХҮСайдын 2016 оны А/57, 2018 оны А/12, АҮЭБСайдын 2025 оны А/73 дугаар тушаал, АМГТГ-ын даргын 2016 оны 89, 2016 оны А/19, 2025 оны А/57 дугаар тушаал зэрэг шийдвэрүүдээр “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн хэрэгжилтэд тулгамдаж байгаа асуудал, цаашид баримтлах чиглэлээр гэрээг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгүүдийг байгуулж ажилласан.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Ажлын хэсгүүд Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх асуудлаар гэрээлэгчтэй удаа дараа уулзалт хийж, албан бичгээр санал солилцсон боловч гэрээлэгчийн зүгээс БХГ-ээг хэвээр хадгалах хатуу байр суурь барьсаар байгаа тул тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Иргэний хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт *"Шинээр баталсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна."* гэж заасны дагуу Бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна.

Иймд Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчилсэн нөхцөлд Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-ний хавсралт В.2.1к1-д заасан захиргааны зардал 6 хувийг Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д заасантай нийцүүлэх боломж бүрдэнэ.

Тайлангийн төсөлд тусгагдсан албан шаардлагад өгөх тайлбар, санал

Бүтээгдэхүүн хуваах гэрээт БХГ-97 талбайн 2014-2018 оны хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад Үндэсний аудитын газар /ҮАГ/-аас хийсэн аудитаар БХГ-ний 8.4.в-д *"... экспортын үнийг тогтоохдоо экспортын цэгээс гэрээт түүхий тосыг нийлүүлэх тодорхой цэг хүртэлх өртөг зардлыг хасч тооцно..."* гэж заасны дагуу танкфармын зардлыг борлуулалтын зардлаас хасаж, өртөг нөхөгдөх зардалд тооцох үндэслэлээр Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны орлогын зөрүүнд 4,094,004.96 сая ам.доллар буюу 8,633,558,989.95 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх албан шаардлага өгсөн.

Дээрх албан шаардлагыг хүчингүй болгуулахаар Доншен газрын тос (Монгол) ХХК-иас гаргасан нэхэмжлэлийг 3 шатны шүүхээр хэлэлцэж, улмаар Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 15 дугаар тогтоолоор нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.1-д *"Шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу явуулна."* гэж, 136 дугаар зүйлийн 136.1-д *"Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байна."* гэж хуульчилсан байна.

ҮАГ-аас дээрх үндэслэлээр БХГ-97 талбайн 2019-2021 онд хамаарах өртөг нөхөгдөх зардал, газрын тосны борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хийсэн аудитаар 981,929.53 сая ам.доллар буюу 2,797,320,824.00 төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн актыг тогтоосон. АМГТГ-ын 2021 оны 9 дүгээр сарын 4/3861, 2024 оны 3 дугаар сарын 3/1023, 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/690, 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 3/4918 дугаар албан бичгүүдээр ҮАГ-ын баталгаажуулалтын тайланд тусгагдсан 2014-2021 оны албан шаардлага болон төлбөрийн актын дагуу нийт 5,075,934.49 ам.доллар буюу 11,430,879,813.95 төгрөгийг ҮАГ-ын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх талаар Доншен газрын тос (Монгол) ХХК-д удаа дараа хүргүүлж ажилласан.

Доншен газрын тос (Монгол) ХХК-иас 2025 оны 10 дугаар сарын 30 өдрийн 365/75 дугаар албан бичгээр хариуг манай газарт ирүүлсэн. /Хавсралт 7 хуудас/

Тайлангийн төсөлд тусгагдсан төлбөрийн актад өгөх тайлбар, санал

АМГТГ-ын өртөг нөхөгдөх зардлын хяналт, шалгалтаар Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны орлогыг 284,639.58 ам.доллароор дутуу тайлагнасан гэж дүгнэсэн. Уг төлбөрийг барагдуулах тухай 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/690, 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 3/4918 дугаар албан бичгийг Доншен газрын тос (Монгол) ХХК-д удаа дараа албан мэдэгдэл хүргүүлж ажилласан.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

АМГТГ-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1/6503 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн аудитын тайлангийн төсөлд өгөх тайлбар, саналыг судалж үзэхэд аудитын тайлан, зөвлөмжид тусгасан арга хэмжээний талаар хийж хэрэгжүүлсэн, төлөвлөсөн ажил болон тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар дурдсан бөгөөд тайлангийн утга агуулгад зарчмын зөрүүтэй саналгүй байх тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж шийдвэрлэв.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Дүгнэлт

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч нарын аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах нэгдсэн дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Гэрээлэгч нарын өртөг нөхөгдөх зардлын тайлан мэдээг тайлагнаж ирүүлэх хугацаа, Төрийн захиргааны байгууллага тайланг хянаж шалган, дүгнэлт гаргаж ТАБ-д ирүүлэх хугацааг нарийн тодорхой заагаагүйгээс аудитаар илэрсэн алдаа зөрчлүүд залруулагдахгүй, дараагийн жилүүдэд давтан гарснаар баталгаажуулах аудитад хүндрэл учирч, аудитын дүн дүгнэлт, зөвлөмж хэрэгжихгүй, үр дүнгүй болж байна.
2. Гэрээлэгчид аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь жил бүрийн аудитаар тогтоосон төлбөрийн акт барагдахгүй хуримтлагдаж, төлж барагдуулж чадахгүй болох мөн Төрийн аудитын байгууллага цаашид аудит хийх боломжгүй болох эрсдэл үүсэхээр байгаад анхаарах шаардлагатай.
3. МУЗГ-аас баталсан БХГ болон Салбарын сайд газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл олгосон байхад хууль тогтоомжийн дагуу холбогдох эрх олгохгүй, үйл ажиллагаанд саад учруулж буй орон нутгийн засаг захиргааны шийдвэрээс шалтгаалан зарим гэрээлэгч үйл ажиллагаа явуул чадахгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй байдал үүссэн байна.
4. Ашигт малтмал, газрын тосны газар нь гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардалд тооцох өмнөх онуудын мөнгөөр төлөгдөөгүй өглөг, борлуулалтын зардал хүлээн зөвшөөрөх шалгуур үзүүлэлтүүдийг заавар аргачлалаар хангаагүй нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.19-т "газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах стандарт, дүрэм, журам, зааврыг боловсруулж батлуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих" гэсэнтэй нийцээгүй байна.
5. Ашигт малтмал, газрын тосны газар нь Доншен газрын тос Монгол ХХК-ийн газрын тосны хөрөнгө, нөөцийн хөдөлгөөний бүртгэлийг Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын дагуу санхүүгийн тайланд тайлагнасан эсэхийг хянаж, дүгнэх шаардлагатай байна.
6. Монгол Улсын Засгийн газарт ногдох орлого, төлбөр, хураамж, урамшууллыг хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлж байгааг хянаж, дүгнээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т "Газрын тосны борлуулалтын орлогоос ЗГ-т ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34-р зүйлд заасан төлбөр урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх" гэсэнтэй нийцээгүй байна.
7. Петроматад ХХК нь 2021 онд ашиглалтын үйл ажиллагаанд шилжиж, санхүүгийн тайланд хайгуул үнэлгээний хуримтлагдсан хөрөнгийг баталгаажсан нөөцийн тоо хэмжээнд үндэслэн Газрын тосны хөрөнгөд шилжүүлэн тайлагнаагүй, 2022 онд хайгуул үнэлгээний хөрөнгийг 2,939,136,957.51 төгрөгөөр, 2023 оны санхүүгийн тайланд Газрын тосны хөрөнгийг 2,889,863,766.87 төгрөгөөр нэмэгдүүлэн тайлагнасан нь СТОУС болон МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журамд нийцээгүй байна.
8. Ашигт малтмал, газрын тосны газар нь 2022-2023 оны Бараа материал, Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийг АМГТГ хянаж ирүүлээгүй нь БХГ болон хууль тогтоомжид нийцээгүй байна.
9. Өмнөх аудитуудаар газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдэд тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарал хандуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад:

1. Гэрээлэгчийн тайлагнасан борлуулалтын зардлыг хүлээн зөвшөөрөх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, заавар аргачлалаар хангах;
2. Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч нарын бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг эрчимжүүлж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг холбогдох төрийн захиргааны байгууллагад даалган, хэрэгжилтийг хангуулах;
3. МУЗГ-аас баталсан БХГ болон Салбарын сайд газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл олгосон байхад хууль тогтоомжийн дагуу холбогдох эрх олгохгүй, үйл ажиллагаанд саад учруулж буй орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаанд эрх зүйн зохицуулалт бий болгох талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;
4. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах, улсын дээд шүүхийн гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;

Ашигт малтмал, газрын тосны газарт:

1. Ашигт малтмал, газрын тосны газар нь Доншен газрын тос Монгол ХХК-ийн газрын тосны хөрөнгө болон нөөцийн хөдөлгөөний бүртгэлийг 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын 9 дүгээр зүйлийн 9.4.7-д "ашиглалтын үеэс эхлэн газрын тосны хөрөнгө дансыг олборлосон бүтээгдэхүүний нэгжид үндэслэн хорогдуулан бүртгэнэ", тайлант оны ашиглалтын үйл ажиллагааны зардлыг 9.4.9-т "олборлолтын үйл ажиллагааны зардлуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар тайлагнана" гэж заасны дагуу санхүүгийн тайлантай уялдуулан тайлагнасан эсэхийг хянаж, дүгнэх;
2. Ашигт малтмал, газрын тосны газар болон Гэрээлэгч нар Газрын тосны тухай хуулийн 34 дүгээр зүйл, БХГ-ний 13 дугаар зүйлд заасан урамшуулал, үйлчилгээний хөлс, бусад төлбөр тооцоог Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т "Газрын тосны борлуулалтын орлогоос ЗГ-т ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34-р зүйлд заасан төлбөр урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх" гэж заасны дагуу жил бүрийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлагнах, хугацаандаа төлөөгүй үед гэрээлэгчээр хугацаанд нь төлүүлж байх;
3. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, тухайн тайлан мэдээнүүдийг тухайн цаг хугацаанд нь шалгаж, алдаа зөрчлийг тухай бүр залруулсны дараа дараагийн тайланг хүлээн авдаг системтэй болох;
4. Хяналт шалгалт хийсэн өртөг нөхөгдөх зардлын тайлангийн санхүүгийн анхан шатны баримтыг иж бүрэн хангалтай нотлох баримтын шаардлагад нийцүүлж бүрдүүлэх, хяналт шалгалтын дүнг гэрээлэгчид танилцуулж, өртөг нөхөгдөх зардлаас хасагдах зардал болон хяналтаар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрүүлж, аливаа маргаан зөрчлийг эцэслэн шийдвэрлэсэн дүгнэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлж байхаар Газрын тосны бүртгэл тооцооны журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
5. Газрын тосны бүртгэл тооцооны журамд заасны дагуу Петроматад ХХК-ийн санхүүгийн тайланд Хайгуул үнэлгээний хуримтлагдсан хөрөнгийг баталгаажсан нөөцийн тоо хэмжээнд үндэслэн газрын тосны хөрөнгөд шилжүүлэн бүртгэх, ашиглалтын үед гарсан 2,939,136,957.51 төгрөг, Газрын тосны хөрөнгөд нэмэгдүүлэн тайлагнасан 2,889,863,766.87 төгрөгийн олборлолтын үйл



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

ажиллагааны зардлуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар залруулж тайлагнах, журмын зүйл заалтыг мөрдүүлэх;

6. БХГ-ээр хүлээсэн жил бүр орон нутгийн хөгжлийн санд орлого төвлөрүүлэх үүргийг Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.17 дахь заалтын дагуу сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг давхардуулахгүйгээр ялгаж гэрээнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах;
7. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах, улсын дээд шүүхийн гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, хэрэгжүүлээгүй гэрээлэгч нарт хариуцлага тооцож ажиллах.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 1

ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Доншен газрын тос Монгол ХХК-ийн БХГ-97 талбай

		/ам.доллар/	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /ам.доллар/	Аудитын байгууллагаас гаргасан шийдвэр
1	2	4	5
А. САНХҮҮТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ			
АМГТГ-ЫН ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ			
1	Гэрээлэгчийн борлуулалтын 3, 4-р улирлын тайлангийн зардлыг хянаж, дүгнэхэд шилжүүлэлтийн зардал 95.0 мянган ам.доллар, цалин хөлс 394.2 мянган ам.доллар, цахилгааны зардал 67.3 мянган ам.доллар, бараа материалын зардал 81.1 мянган ам.доллар, нийт 637.6 мянган ам.долларын зардал илүү тайлагнасан нь БХГ-ний 8.4.в-д "Экспортын үнийг тогтоохдоо экспортын цэгээс гэрээт түүхий тосыг нийлүүлэх тодорхой цэг хүртэлх өртөг зардлыг хасаж тооцно" гэсэнтэй нийцэхгүй байна.	637,621.20	ӨНЗ-д шилжүүлэн залруулах
2	Гэрээлэгч борлуулалт шилжүүлэлтийн зардалд мөнгөөр төлөөгүй болон ажлын төсөвт тусгагдаагүй 450.9 мянган ам.долларын зардал тайлагнасныг Газрын тосны бүртгэл тооцооны журмын 3.1.2, 3.1.3 заалтуудыг үндэслэн өртөг нөхөгдөх зардалд шилжүүлэн тооцох боломжгүй тул борлуулалтын зардлаас хасаж тооцсон.	450,871.89	Борлуулалтын зардлаас хасаж тооцох
3	АМГТГ-ын Борлуулалтын зардлын тооцооллын зөрүүгээс цэвэр орлого 1,088.4 ам.доллараар зөрүүтэй тайлагнасан нь Газрын тосны тухай хуулийн 11.2.14-д "санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тос хуваах тооцоог энэ хуулийн 7.1.4-т заасан журмын дагуу үнэн зөв гаргаж, төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх" гэсэнтэй нийцэхгүй байна.	1,088,493.11	Борлуулалтын орлогыг залруулах
4	ӨНЗ-ын тайланд мөнгөөр төлөгдөөгүй 1,099.7 мянган ам.долларын ажил гүйлгээг тайлагнасан нь Газрын тосны бүртгэл тооцооны журмын 2.2.1-д "өртөг нөхөгдөх зардлаас түүнд ногдуулсан аливаа хөнгөлөлт, буцаалтыг хасаж, мөнгөөр төлсөн зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцно" гэж заасантай нийцэхгүй байна.	1,099,736.15	ӨНЗ-аас хасах
5	ӨНЗ-ын тайланд анхан шатны баримтын бүрдэл дутуу болон баримтгүй 312.9 мянган ам.долларын ажил гүйлгээг тайлагнасан нь Газрын тосны бүртгэл тооцооны журмын 3.1.3-д "анхан шатны баримтын бүрдэл дутуу, эсхүл зөрчилтэй, гэрээ болон нэхэмжлэлээс зөрүүтэй, нэр дансаар хийсэн гүйлгээ, холбогдох ажлын төлөвлөгөө төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн, эсхүл гэрээнд зөвшөөрөөгүй зардал" гэж заасантай нийцэхгүй байна.	312,982.86	ӨНЗ-аас хасах
6	ӨНЗ-ын тайланд татвар хураамж, хандив тусламжийн 786.0 мянган ам.долларын ажил гүйлгээг тайлагнасан нь Газрын тосны бүртгэл тооцооны журмын 3.1.7-д "МУ болон гадаад улсад төлсөн албан татвар, хураамж, төлбөр урамшуулал, бусад үйлчилгээний хөлс", 3.1.12-т "МУ-ын шүүх болон эрх бүхий бусад байгууллагаас ногдуулсан төлбөр, акт, торгууль, алданги, гэрээний талын ашиг сонирхол, олон нийттэй харилцах харилцааг сайжруулах, зар сурталчилгааатай холбоотой зардал, бусдад өгсөн хандив, тусламж", 3.1.28-д "бүх төрлийн хүлээн авалт, бэлэг дурсгалын зардал" гэж заасантай нийцэхгүй байна.	786,037.88	ӨНЗ-аас хасах
7	ӨНЗ-ын тайланд удирдлагын зардалд хамаарах 74.6 мянган ам.долларын ажил гүйлгээг тайлагнасан нь Газрын тосны бүртгэл тооцооны журмын 3.1.23-д "гэрээлэгч эсвэл оператор компанийн газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байгаа МУ болон гадаад улс дахь гүйцэтгэх удирдлага, түүнд үйлчлэх үйлчилгээний ажилтнууд, захиргааны ажилтнууд болон захиргааны үйл ажиллагаатай холбогдон гарсан зардлууд..." гэж заасантай нийцэхгүй байна.	74,599.42	ӨНЗ-аас хасах
8	АМГТГ-ын хяналтаар гэрээлэгчийн борлуулсан газрын тосны цэвэр борлуулалтын орлогын тооцооллын зөрүүгээс үүссэн газрын тосны нөөц ашигласны төлбөрийг МУЗГ-т ам.долларыг дутуу төвлөрүүлсэн нь Газрын тосны тухай хуулийн 31.1-д "Газрын тос,	81,636.98	Төлбөрийн акт



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

	байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 хувь байна" гэсэнтэй нийцэхгүй байна.		
9	АМГТГ-ын хяналтаар гэрээлэгчийн бүтээгдэхүүн хуваах тооцооллын зөрүүгээс ашигт газрын тосны МУЗГ-т төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлсэн нь 11.2.14-д "санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тос хуваах тооцоог энэ хуулийн 7.1.4-т заасан журмын дагуу үнэн зөв гаргаж, төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх" гэсэнтэй нийцэхгүй байна.	203,002.60	Төлбөрийн акт
	ЗӨРЧЛИЙН ДҮН	4,734,982.09	
САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧИЙН ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ			
10	АМГТГ нь Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш гэрээлэгчийн санхүүгийн тайланд газрын тосны хөрөнгийг залруулаагүй, газрын тосны нөөцийн хөдөлгөөний тооцоотой уялдуулан санхүүгийн тайлан дахь газрын тосны хөрөнгийг хянаагүй нь Газрын тосны бүртгэл тооцооны журмын 9.3.16-д "Хайгуулын ажлын үр дүнд үр ашигтай нээлт тогтоогдож, ордыг ашиглах талаар гэрээлэгч эсхүл оператор компани шийдвэр гаргасан үед Хайгуул үнэлгээний хөрөнгийг Газрын тосны хөрөнгөнд шилжүүлэн бүртгэнэ", 9.4.7-д "ашиглалтын үеэс эхлэн газрын тосны хөрөнгө дансыг олборлосон бүтээгдэхүүний нэгжид үндэслэн хорогдуулан бүртгэнэ", 9.4.9-д "олборлолтын үйл ажиллагааны зардлуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар тайлагнана" гэсэнтэй нийцэхгүй байна.	-	Зөвлөмж өгөх
11	АМГТГ-ын 2022 оны ӨНЗ-ыг хянасан дүнгээс 7,598.05 ам.долларын байгаль орчны зардлыг анхан шатны баримт дутуу, зөрчилтэй үндэслэлээр хасаж, 937.37 ам.долларын үйл ажиллагааны зардлыг нэмж, зөрүү 6,660.71 ам.долларыг ӨНЗ-аас хасаж тооцов. Энэ нь Газрын тосны бүртгэл тооцооны журмын 3.1.3-д "Анхан шатны баримтын бүрдэл дутуу, эсхүл зөрчилтэй, гэрээ болон нэхэмжлэлээс зөрүүтэй нэр, дансаар хийсэн гүйлгээ, холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн, эсхүл гэрээнд зөвшөөрөөгүй зардал" гэж заасантай нийцэхгүй байна.	6,660.71	ӨНЗ-аас хасах
12	АМГТГ нь өмнөх онуудын мөнгөөр төлөгдөөгүй 3,537,709.58 ам.долларын зардлыг гэрээлэгчийн тайлант оны зардалд нэмж тооцож, гэрээлэгчийн 2022 оны ӨНЗ-ыг 2,858,799.80 ам.доллараар зөрүүтэй дүгнэсэн нь Газрын тосны бүртгэл тооцооны журмын 2.2.1-д "өртөг нөхөгдөх зардлаас түүнд ногдуулсан аливаа хөнгөлөлт, буцаалтыг хасаж, мөнгөөр төлсөн зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцно" гэсэнтэй нийцэхгүй байна.	2,858,799.80	ӨНЗ-аас хасах
13	ӨНЗ-ын нийт дүнгээс тооцох эх компанийн захиргааны зардлыг аудитын дараах тооцооллоос Газрын тосны бүртгэл тооцооны журмын 2.1.16-д "Тухайн жилийн өртөг нөхөгдөх зардлын дүнгээс бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцсон захиргааны зардал" гэж заасны дагуу гэрээлэгчийн тайлагнасан захиргааны зардлыг хасаж тооцов.	58,377.55	ӨНЗ-аас хасах
14	БХГ-ний 2.1.и-д "Газрын тостой холбоотой үйл ажиллагааны явцад Гэрээлэгчийн удирдлагын захиргааны зардал нь энэхүү Гэрээний дагуу Гэрээлэгчийн Газрын тосны үйл ажиллагааны зардлын зургаан (6) хувиар жил бүр тооцогдоно" гэж заасны дагуу захиргааны зардал тооцох 6.0 хувийн дүн тооцооллын зөрүүг хасаж тайлагнах.	171,927.63	АМГТГ-ын хянасан дүнгээс хасаж залруулах
	ЗӨРЧЛИЙН ДҮН	3,095,765.69	
Б. НИЙЦЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ			
15	АМГТГ нь гэрээлэгчийн Ус шахалтын өдөр тутмын бүртгэлийг аудитад ирүүлээгүй, АМГТГ болон гэрээлэгчийн БХГ-97 талбайн 2022 оны "Хий, тос, усны олборлолт, ачилт буулгалтын хэмжээг баталгаажуулсан протокол"-д баталгаажуулсан хэрэглэсэн усны тооцоо нь усны төлбөрийн нэхэмжлэхтэй 58,952.0 м3 усаар зөрүүтэй. Дээрх протоколд гэрээлэгчийн жилийн эцэст цооногууд болон байгууламжид байгаа усны үлдэгдлийг хэмжээгүй, усны орлого, зарлага, үлдэгдлийн тооцоог хийж баталгаажуулаагүй нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3-д "газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих", 10.3.2-т "байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хуулиар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих", Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д "ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах" гэсэнтэй нийцээгүй.		Албан шаардлага
16	АМГТГ-ын гэрээлэгчийн борлуулалтын зардлыг хянахдаа зардлуудыг ангилал хооронд гүйлгэсэн, нэг ижил зардлыг өөрөөр тооцсон, зарим зардлын хуваарилалт тооцоолол тодорхойгүй зэрэг нь Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 5.6.1-д "ашигт		Зөвлөмж өгөх



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

	газрын тосны хэмжээг тухайн хуанлийн сард хүргэлтийн цэг дээр хэмжсэн газрын тосноос нөөц ашигласны төлбөр болон өртөгт газрын тос, борлуулалттай холбоотой зардлыг хасаж тооцно. Борлуулалттай холбоотой зардлыг төрийн захиргааны байгууллагатай зөвшилцож, холбогдох гэрээгээр зохицуулна" гэсэнтэй нийцэхгүй байна.		
1 7	Гэрээлэгч нь МУЗГ-т ногдох 2022 оны роялти болон тосны орлогоос 975,754.38 ам.долларыг хугацаа хоцроон төсөвт төвлөрүүлж, БХГ-ний 10 дугаар зүйлд заасан урамшуулал, үйлчилгээний хөлс, байгаль орчныг нөхөн сэргээх үүргийг барьцаа, бусад төлбөрийг төсөвт төвлөрүүлсэн эсэхийг АМГТГ-ын тайланд дүгнээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Газрын тосны тухай хуулийн 9.1.9-д "Газрын тосны борлуулалтын орлогоос ЗГ-т ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34-р зүйлд заасан төлбөр урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх", ГТБТЖ-ын 5.4.1-т "Нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тосны тооцоог олборлож худалдсан хуанлийн сар бүр хийнэ", ГТБТЖ-ын 11.1-т "Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3, 9.1.8, 9.1.10, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, зарцуулсан зардал, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, төлбөр урамшууллын төлөлт, борлуулсан газрын тосны орлогын тооцоог үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавьж ажиллана" гэсэнтэй нийцэхгүй байна.		Зөвлөмж өгөх
1 8	Гэрээлэгчийн орон нутгийг хөгжүүлэх урамшуулал 29,711.44 ам.долларыг дутуу төлж, төлбөр тооцоог АМГТГ-тай тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Газрын тосны тухай хуулийн 9.1.9-д "Газрын тосны борлуулалтын орлогоос ЗГ-т ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34-р зүйлд заасан төлбөр урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх", ГТБТЖ-ын 6.2.4-т "орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг гэрээт жил эхэлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу орон нутгийн хөгжлийн санд төлнө" гэсэнтэй нийцэхгүй байна.	29,711.44	Албан шаардлага
	ЗӨРЧЛИЙН ДҮН	29,711.44	
	НИЙТ ЗӨРЧЛИЙН ДҮН	7,860,459.22	



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 2

ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Петроматад ХХК-ийн Матад ХХ талбай

/ам.доллар/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт	Үүнээс			Аудитын байгууллагаас гаргасан шийдэл
			2021.7-12	2022	2023	
1	2	3	4	5	6	7
А. САНХҮҮТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ						
АМГТГ-ЫН ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ						
1	ӨНЗ-ын тайланд мөнгөөр төлөгдөөгүй 5,806.19 ам.долларын байгууламжийн зураг зүйн ажлын зардлыг тайлагнасан байна.	5,806.19	-	5,806.19	-	ӨНЗ-аас хасав.
2	Төлбөрийн цахим систем и-баримтаар баталгаажуулахгүй 31,869.21 ам.доллар, анхан шатны баримтаар нотлогдоогүй 30,666.95 ам.доллар, хөнгөлөлт 4.97 ам.доллар, нийт 62,541.23 ам.долларын зардлыг ӨНЗ-д тайлагнасан байна.	62,541.23	19,035.37	41,464.27	2,041.59	ӨНЗ-аас хасав.
3	АМГТГ-т анхдагч мэдээ, тайлан ирүүлээгүй 3 хэмжээст газар хөдлөлтийн ашиглалтын загварчлалын ажлын зардлыг ӨНЗ-д тайлагнасан байна.	9,500.00	9,500.00	-	-	ӨНЗ-аас хасав.
4	Татвар, торгууль, төлбөр хураамжийн зардал 13,683.31 ам.доллар, сургалтын зардал 3,528.40 ам.доллар, нийт 17,211.71 ам.долларын зардлыг ӨНЗ-д тайлагнасан байна.	17,211.71	3,849.63	13,362.08	-	ӨНЗ-аас хасав.
5	ӨНЗ-ын тайланд төлөвлөгөө, төсөвт тусгагдаагүй, төсөв хэтрүүлсэн 140,258.54 ам.долларыг давхардуулан тайлагнасан байна.	140,258.54	-	19,052.58	121,205.96	ӨНЗ-аас хасав.
6	ӨНЗ-ын дүнд захиргааны зардал 63,077.70 ам.долларыг давхардуулан тайлагнасан байна.	63,077.70	61.53	41,529.43	21,486.74	ӨНЗ-аас хасав.
7	Санхүүгийн тайланд 2022 оны тайлант үед хайгуул үнэлгээний хөрөнгийг газрын тосны хөрөнгөнд шилжүүлэн тайлагнаагүй байна.	-	-	-	-	Санхүүгийн тайланд Хайгуулын хөрөнгийг Газрын тосны хөрөнгөөр залруулан толилуулах зөвлөмж өгөв
Зөрчлийн дүн		298,395.37	32,446.43	121,214.55	144,734.29	
АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ						
8	АМГТГ-ын 2022-2023 оны ӨНЗ-ыг хянасан дүнгээс 2,174.28 ам.долларын үйл ажиллагааны зардлыг хасаж, тайлант хугацаанд нэмэгдсэн тоног төхөөрөмжийн, шуудан цахилгааны төлбөр 8,260.72 ам.долларыг нэмж, зөрүү 6,086.45 ам.долларыг ӨНЗ-д тооцлоо.	6,086.45	-	6,012.42	74.02	ӨНЗ-д нэмж залруулав



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

9	ӨНЗ-ын нийт дүнгээс тооцох эх компанийн захиргааны зардлыг хяналт шалгалтын дараах тооцооллоос гэрээлэгчийн тайлагнасан захиргааны зардлыг хасаж тооцлоо.	12,255.81	1,097.25	4,353.09	6,805.47	ӨНЗ-аас хасав
10	Захиргааны зардал тооцох 5.0 хувийн дүн тооцооллын зөрүүг нэмж залрууллаа.	304.32	-	300.62	3.7	ӨНЗ-д нэмж залруулав
11	Санхүүгийн тайланд 2022 оны тайлант үед хайгуул үнэлгээний хөрөнгийг 2,939,136,957.51 төгрөгөөр буюу /2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Монголбанкны хаалтын ханш/ нэмэгдүүлэн бүртгэсэн байна.	853,259.29	-	853,259.29		Орлогын дэлгэрэнгүй тайланд зардлаар тайлагнаж залруулах зөвлөмж өгөв.
12	Санхүүгийн тайланд 2023 оны тайлант үед газрын тосны хөрөнгийг 829,473.49 ам.доллар буюу 2,889,863,766.87 төгрөгөөр нэмэгдүүлэн тайлагнасан байна.	829,473.49	-	-	829,473.49	
Зөрчлийн дүн		1,701,379.36	1,097.25	863,925.42	836,356.68	
Б. НИЙЦЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ						
12	Гэрээлэгч 2022 онд 595,883,255.46 төгрөг буюу 174,223.48 ам.доллар, 2023 онд 42,625,427.50 төгрөг буюу 12,229.94 ам.долларын үндсэн хөрөнгө худалдан авч ӨНЗ-д тайлагнасан байна. /Үүнээс компьютер, түүний дагалдах хэрэгсэл 1,803.82 ам.доллар, програм хангамж 3,042.72 ам.долларын зардлыг ӨНЗ-аас хасаж тооцсон/ АМГТГ-ын зүгээс "орон нутгийн эсэргүүцлийн улмаас үйл ажиллагааг одоог хүртэл эхлүүлж чадаагүй, бүтээн байгуулалтын ажилд зориулан худалдан авсан тоног төхөөрөмжийг талбай дээр хүлээн авсан тул ашиглалтад тавьж олгосон гэж үзсэн" гэсэн тайлбар өгсөн ч дүгнэлт тайланд хэлэлцэн баталгаажуулсан шийдвэр хавсаргаагүй байна. Энэ нь МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын 2.2.2-т "Хайгуул, ашиглалт, татан буулгалтын үйл ажиллагаанд зориулан худалдан авсан тусгай зориулалтын машин, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, тоноглолын зардлыг ашиглалтад оруулсан үеэс өртөг нөхөгдөх зардалд тооцно" гэж заасантай нийцэхгүй байна.	-	-	-	-	АМГТГ-т тухай бүрд нь шийдвэрлэж баталгаажуулж байх зөвлөмж өгөв.
13	АМГТГ нь гэрээлэгчийн 2022, 2023 оны бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хийгээгүй нь МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын 4.3.1-д "ГТАЭТЗБ нь гэрээлэгч, эсхүл оператор компанийн үйл ажиллагааны эд материал, биет хөрөнгө, барилга байгууламжийн тооллогыг хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.	-	-	-	-	АМГТГ-т гэрээлэгчийн жил бүрийн Бараа материал, Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлд хяналтын тооллого хийж бүртгэлийг Төрийн аудитын байгууллагад ирүүлэх албан шаардлага өгөв.



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

14	АМГТГ-ын дүгнэлт тайланд БХГ-ний 15.3-т заасан хяналт шалгалтын хэрэгжилтийг гэрээлэгчийн ирүүлсэн тайлан мэдээг үндэслэсэн талаар дурдсан ч ямар тайланг хэдий хугацаанд хүлээн авсан талаар бүртгэлжүүлж, тухайн тайлан мэдээнүүдийг тухайн цаг хугацаанд нь шалгаж, алдаа зөрчлийг тухай бүр залруулаагүй байна. Энэ нь БХГ-ний хавсралт Г.1.7.2-т "хуанлийн улирал бүр дууссанаас 30 хоногийн дотор, тайлант жил дууссанаас хойш 60 хоногийн дотор /санхүүгийн тайлан, тодруулга, үндсэн хөрөнгө, бараа материалын орлого, зарлага, үлдэгдлийн дэлгэрэнгүй тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, захиргааны зардлын тайлан/ гэж заасантай нийцэхгүй байна.	-	-	-	-	АМГТГ-т БХГ-ний 15.3-т заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, тухайн тайлан мэдээнүүдийг тухайн цаг хугацаанд нь шалгаж, алдаа зөрчлийг тухай бүр залруулсны дараа дараагийн тайланг хүлээн авдаг системтэй болох зөвлөмж өгөв.
15	Тайлант онд Газрын тосны тухай хуулийн 34 дүгээр зүйл, БХГ-ний 13 дугаар зүйлд заасан урамшуулал, үйлчилгээний хөлс, бусад төлбөрт 173,600.00 ам.долларыг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээс 148,231.59 ам.долларыг төвлөрүүлж, сургалтын төлбөрийн дутуу 14,876.71 ам.долларын төлбөрийг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр, орон нутгийг хөгжүүлэх урамшууллын үлдэгдэл 2022 оны 5,088.00 ам.доллар, 2023 оны 20,280.41 ам.доллар, нийт 25,368.41 ам.долларыг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хугацаа хоцроон төлсөн байна. АМГТГ нь гэрээлэгчийн тайлант онд төсөвт төвлөрүүлэх орлого, үлдэгдлийн дүнг тооцоо нийлж, баталгаажуулаагүй. Дүгнэлт тайланд сургалтын төлбөрийн дутуу 14,876.71 ам.долларын төлбөрийг 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр төлсөн талаар тэмдэглэж, орон нутгийн хөгжлийн сангийн дутуу төлбөрийг төлөх эсэх талаар дүгнээгүй байна. Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9.1.9-д "Газрын тосны борлуулалтын орлогоос ЗГ-т ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34-р зүйлд заасан төлбөр урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх", ГТБТЖ-ын 11.1 "Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3, 9.1.8, 9.1.10, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, зарцуулсан зардал, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, төлбөр урамшууллын төлөлт, борлуулсан газрын тосны орлогын тооцоог үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавьж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.	25,368.41	-	-	25,368.41	АМГТГ-т БХГ-нд жил бүр төлбөр урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх гэж заасны дагуу жилийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлагнах, хугацаандаа төлөөгүй үед төлүүлэх тодорхой арга хэмжээ авч ажиллах албан шаардлага өгөв.
НИЙТ ЗӨРЧЛИЙН ДҮН		2,025,143.14	33,543.68	985,139.97	1,006,459.38	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 263 /А0171328
СНАГ-2025/09-НА-НА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасны дагуу газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваар гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй "Доншен Газрын Тос Монгол" ХХК-ийн 2022 оны батлагдсан төлөвлөгөө төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Доншен газрын тос Монгол" ХХК нь 2022 оны борлуулалтын зардлыг 1,088,493.11 ам.доллараар илүү тайлагнаснаас роялти 81,636.98 ам.доллар, газрын тосны орлого 203,002.60 ам.доллар, нийт 284,639.58 ам.доллар буюу 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Монгол банкны хаалтын ханш болох 3,444.60 төгрөгөөр тооцон 980,469,497.27 (есөн зуун наян сая дөрвөн зуун жаран есөн мянга дөрвөн зуун ерэн долоон төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.14-т "санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тос хуваах тооцоог энэ хуулийн 7.1.4-т заасан журмын дагуу үнэн зөв гаргаж, төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх", Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Газрын тосны бүртгэл тооцооны журам"-ын 5.6.1-т "ашигт газрын тосны хэмжээг тухайн хуанлийн сард хүргэлтийн цэг дээр хэмжсэн", Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 47 дугаар тогтоолоор баталсан "БХГ-97" Бүтээгдэхүүн хуваах гэрээний 8.4.в-д "... Экспортын үнийг тогтоохдоо, экспортын цэгээс гэрээт түүхий тосыг нийлүүлэх тодорхой цэг хүртэлх өртөг зардлыг хасаж тооцно..." гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-т "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй", 4.2.3.8-т "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Доншен газрын тос Монгол ХХК-аар 284,639.58 (хоёр зуун наян дөрвөн мянга зургаан зуун гучин есөн доллар тавин найман цент) ам.доллар буюу 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Монгол банкны хаалтын ханш болох 3,444.60 төгрөгөөр тооцон 980,469,497.27 (есөн зуун наян сая дөрвөн зуун жаран есөн мянга дөрвөн зуун ерэн долоон төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийг нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар)-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Л.НЯМТӨМӨР
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 1284/А0111241
СНАГ-2025/09-НА-НА

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 37 дугаар зүйлийн 37.2, 37.3 дахь хэсгийг тус тус үндэслэн газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваар гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн батлагдсан төлөвлөгөө төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал, газрын тосны газар нь гэрээлэгчээс ирүүлсэн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг анхан шатны баримтад үндэслэн хянахдаа гэрээлэгчийн саналыг нягталж, эцэслэн шийдвэрлээгүй дүгнэлтийг ТАБ-д ирүүлсэн, өмнөх аудитаар ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчтэй хамааралтай өгсөн аудитын шийдвэр буюу нийт 31,420,638.47 ам.долларын 3 төлбөрийн акт, 12,392,502.03 ам.долларын 9 албан шаардлага, 46 зөвлөмж өгснөөс 31,420,638.47 ам.долларын 3 төлбөрийн акт, 12,392,502.03 ам.долларын 9 албан шаардлага, 38 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэсэн заалтыг хэрэгжүүлэх шаардлага үүссэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй холбогдох буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /Г.Дамдинням/-д даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 1285 / А0171328
СНАГ- 2025/09-НА-НА

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасны дагуу газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй "Петроматад" ХХК-ийн 2022, 2023 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Петроматад ХХК нь Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу орон нутгийг хөгжүүлэх урамшуулал болох 2022 оны үлдэгдэл 5,088.00 ам.доллар, 2023 оны үлдэгдэл 20,280.41 ам.доллар, нийт 25,368.41 ам.долларыг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр буюу хугацаа хоцроож төвлөрүүлсэн байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т "газрын тосны борлуулалтын орлогоос Засгийн газарт ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх", Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Газрын тосны бүртгэл тооцооны журам"-ын 6.2.4-т "орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг гэрээт жил эхэлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу орон нутгийн хөгжлийн санд төлнө", 11.1-т "Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3, 9.1.8, 9.1.10, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, зарцуулсан зардал, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, төлбөр урамшууллын төлөлт, борлуулсан газрын тосны орлогын тооцоог үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавьж ажиллана", БХГ-ний 13.6.2-т "Гэрээлэгч эсхүл оператор компани орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг гэрээт жил эхэлснээс хойш 60 (жар) хоногийн дотор, цаашид санхүүгийн жил эхэлснээс хойш 30 (гуч) хоногийн дотор орон нутгийг хөгжүүлэх санд төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг хугацаанд нь төвлөрүүлж байх, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, БХГ-ний дагуу төлөх дэмжлэг, урамшууллыг хугацаа хоцроосон, оны эцэст үлдэгдэл төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулах, хуулийн хугацааг мөрдөж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар), Газрын тос, бүтээгдэхүүний газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Чулуунбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Л.НЯМТӨМӨР
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 128Б/А0171328
СНАГ-2025/09-НА-НА

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал, газрын тосны газар нь Газрын тосны бүртгэл тооцооны журмын дагуу гэрээлэгчийн 2022, 2023 оны үйл ажиллагааны эд материал, биет хөрөнгө, байгууламжийн тооллогыг хийгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Газрын тосны бүртгэл тооцооны журам"-ын 4.3.1-т "Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гэрээлэгч, эсхүл оператор компанийн үйл ажиллагааны эд материал, биет хөрөнгө, барилга байгууламжийн тооллогыг хийнэ", 4.3.2-т "Тооллогыг хайгуулын үед болон бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг шилжүүлэх, бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах үед шаардлагатай тохиолдолд, ашиглалтын үед жил бүр хийнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Газрын тосны бүртгэл тооцооны журмын дагуу Ашигт малтмал, газрын тосны газар гэрээлэгчийн эд материал, биет хөрөнгө, байгууламжийн тооллогыг хийж, тооллогын үр дүн, тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлж зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар)-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Л.НЯМТӨМӨР
С.БИЛГҮТЭЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойргь-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

Z: Alban Shaardlaga 2025/1230 SAG-J.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 1287/А0171328
СКАГ-2025/09-НА-НА

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасны дагуу газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваар гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй "Доншен Газрын Тос Монгол" ХХК-ийн 2022 оны батлагдсан төлөвлөгөө төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал, газрын тосны газар болон гэрээлэгчийн БХГ-97 талбайн 2022 оны "Хий, тос, усны олборлолт, ачилт буулгалтын хэмжээг баталгаажуулсан протокол"-д баталгаажуулсан хэрэглэсэн усны тооцоо нь усны төлбөрийн нэхэмжлэхтэй 58,952.0 м3 усаар зөрүүтэй. Дээрх протоколд гэрээлэгчийн жилийн эцэст цооногууд болон байгууламжид байгаа усны үлдэгдлийг хэмжээгүй, усны орлого, зарлага, үлдэгдлийн тооцоог хийж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-д "газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20.2.6, Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д "ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ашигт малтмал, газрын тосны газар, гэрээлэгч болон усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан ус ашиглах гэрээг дүгнэх, сар бүрийн хэрэглэсэн усны тооцооны акт үйлдэхэд төлөөллөө байлцуулж, ус ашиглалтын зөрүүтэй тооцоо бүртгэлийг арилгах санал хүргүүлж ажиллах, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг таслан зогсоож, гэрээлэгчид тавих хяналтыг сайжруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар), Газрын тос, бүтээгдэхүүний газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Чулуунбат) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Л.НЯМТӨМӨР
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 1288/А017-1328
СНАГ-2025/09-НА-НА

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаа жуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Доншен газрын тос Монгол” ХХК нь 2022 онд Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу орон нутгийг хөгжүүлэх урамшуулал болох 29,711.44 ам.долларыг 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр буюу хугацаа хоцроож төвлөрүүлсэн.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т “газрын тосны борлуулалтын орлогоос Засгийн газарт ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Газрын тосны бүртгэл тооцооны журам”-ын 6.2.4-т “орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг гэрээт жил эхэлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу орон нутгийн хөгжлийн санд төлнө”, 11.1-т “Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3, 9.1.8, 9.1.10, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, зарцуулсан зардал, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, төлбөр урамшууллын төлөлт, борлуулсан газрын тосны орлогын тооцоог үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавьж ажиллана”, Бүтээгдэхүүн хуваах гэрээний салшгүй нэг хэсэг болох 2011 оны 10 дугаар сард Газрын тосны хэрэг эрхлэх газар болон гэрээлэгч нарын хооронд байгуулсан протоколын гурав дахь хэсэгт “Доншенг нь Дорноговь аймгийн Хөгжлийн санд жил бүр 40,000 ам.долларыг БХГ-97 блок дээр арилжааны бүтээн байгуулалтын үе шаттай уялдуулан хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр төлнө” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” 4.2.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг хугацаанд нь төвлөрүүлж байх, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг таслан зогсоож, БХГ-ний дагуу төлөх дэмжлэг, урамшууллыг оны эцэст үлдэгдэл төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулах, хуулийн хугацааг мөрдөж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Баянбаатар)-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Л.НЯМТӨМӨР
С.БИЛГҮТЭЙ